

# ХАВДРЫН ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТ

СҮҮЛИЙН 10 ЖИЛИЙН БАРИМТЫН СУДАЛГАА

УЛААНБААТАР ХОТ  
2020 ОН

**ТАЙЛАНГ БИЧСЭН :**

Г.Урангоо	Үндэсний Статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газрын статистикч
Х.Нарантуяа	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн, Эрүүл мэндийн мэдээллийн албаны мэргэжилтэн
Т.Ундармаа	Хавдар судлалын үндэсний төвийн, Бүртгэл, тандалт, эрт илрүүлгийн албаны дарга

**ХЯНАСАН:**

Ч.Баянчимэг	Үндэсний Статистикийн хорооны дэд дарга
А.Амарбал	Үндэсний Статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга
Н.Должинсүрэн	Үндэсний Статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газрын ахлах статистикч

## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	4
ХУРААНГУЙ .....	8
<b>БҮЛЭГ 1. УДИРТГАЛ .....</b>	<b>13</b>
Дэлхийн улс орнуудын өвчлөл, нас баралтын хандлагын тойм, хөтөлбөр .....	13
Монгол Улсын хэмжээнд хавдрыг хяналтад авсан түүх, одоо хэрэгжиж буй бодлого хөтөлбөр .....	14
<b>БҮЛЭГ 2. ХАВДРЫН ӨВЧЛӨЛ .....</b>	<b>16</b>
Элэгний хорт хавдрын өвчлөл .....	22
Ходоодны хорт хавдрын өвчлөл.....	25
Уушгины хорт хавдар .....	27
Улаан хоолойн хорт хавдар .....	29
Умайн хүзүүний хорт хавдар.....	31
<b>БҮЛЭГ 3. ХАВДРЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ.....</b>	<b>34</b>
Хавдрын хяналт, тусламж үйлчилгээ.....	38
<b>БҮЛЭГ 4. ХАВДРЫН УРЬДАЛ ӨВЧНҮҮД.....</b>	<b>43</b>
Хоргүй хавдар /D10-D36/ .....	44
Элэгний хорт хавдрын урьдал өвчнүүд .....	46
Ходоодны хорт хавдрын урьдал өвчнүүд.....	53
Уушгины хорт хавдрын урьдал өвчнүүд .....	57
Улаан хоолойн хорт хавдрын урьдал өвчнүүд .....	60
Умайн хүзүүний хорт хавдрын урьдал өвчнүүд.....	62
<b>БҮЛЭГ 5. ХАВДРЫН НАС БАРАЛТ, ТҮҮНИЙ ШАЛТГААН .....</b>	<b>66</b>
Хүн амын нас баралтын шалтгаан.....	67
Хорт хавдрын шалтгаант нас баралт .....	69
Хорт хавдрын нас баралтын хандлага.....	74
Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт.....	75
Ходоодны хорт хавдрын шалтгаант нас баралт .....	79
Уушгины хорт хавдрын шалтгаант нас баралт.....	81
Улаан хоолойн хорт хавдрын шалтгаант нас баралт.....	84
Умайн хүзүүний хорт хавдрын шалтгаант нас баралт .....	87
<b>БҮЛЭГ 6. ДҮГНЭЛТ .....</b>	<b>90</b>

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ХБӨ	Халдварт бус өвчин
ЭХЯ	Эрүүлийг хамгаалах яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 2. 1. Хавдар өвчний тохиолдол, 2010-2019 он.....	17
Зураг 2. 2. Хавдар өвчний тохиолдлын түвшин, хүйс, насны бүлгээр, 2019 он .....	17
Зураг 2. 3. Хорт хавдрын шинэ тохиолдол, 2010-2019 он.....	18
Зураг 2. 4. Хорт хавдраар шинээр өвчлөгчдийн түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2010, 2019 он.....	18
Зураг 2. 5. Хорт хавдрын шинэ өвчлөлийн түвшин (10000 хүн амд), бүсээр, 2010, 2019 он ....	19
Зураг 2. 6. Хорт хавдрын шинэ өвчлөлийн түвшин (10000 хүн амд ногдохоор), аймаг, нийслэлээр, 2019 он .....	19
Зураг 2. 7. 0-19 насанд тохиолдож буй хорт хавдар, өвчний төрөл, 2010-2019 оны дундаж, хувиар.....	20
Зураг 2. 8. Хорт хавдрын өвчлөлийн түвшин (10000 хүн амд ногдох), зонхилон тохиолдох өвчний төрлөөр,2001-2045 он.....	21
Зураг 2. 9. Хорт хавдрын өвчлөлийн түвшин (10000 хүн амд ногдох), зонхилон тохиолдох өвчлөлийн төрлөөр, 2001-2045 он .....	22
Зураг 2. 10. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин,хүйсээр,дүнд эзлэх хувиар, 2010-2019 он .....	23
Зураг 2. 11. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин, .....	23
Зураг 2. 12. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин, (10000 хүн амд ногдох),.....	24
Зураг 2. 13. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин (10000 хүн амд ногдох), бүсээр,.....	24
Зураг 2. 14. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин, (10000 хүн амд ногдох), аймаг, нийслэлээр, 2019 он .....	25
Зураг 2. 15. Ходоодны хорт хавдрын өвчлөл, 2010-2019 он.....	25
Зураг 2. 16. Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшин, хүйсээр, насны бүлгээр, 2010, 2019 он .....	26
Зураг 2. 17. Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшин, бүсээр, 2010, 2019 он.....	26
Зураг 2. 18. Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшин, бүсээр, 2019 он.....	27
Зураг 2. 19. Уушгины хорт хавдрын өвчлөл, 2010-2019 он.....	27
Зураг 2. 20. Уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшин, насны бүлэг, хүйсээр, 2010-2019 он .	28
Зураг 2. 21. Уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшин, бүсээр, 2010, 2019 он .....	28
Зураг 2. 22. Уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшин, аймаг, нийслэлээр, 2019 он .....	29
Зураг 2. 23. Улаан хоолойн хорт хавдрын өвчлөл, 2010-2019 он .....	29
Зураг 2. 24. Улаан хоолойн хорт хавдрын өвчлөлийн түвшин, хүйс, насны бүлгээр, 2010, 2019 он .....	30
Зураг 2. 25. Улаан хоолойн хорт хавдрын өвчлөлийн түвшин, бүсээр, 2010, 2019 он .....	30
Зураг 2. 26. Улаан хоолойн хорт хавдрын өвчлөлийн түвшин, аймаг, нийслэлээр, 2019 он ....	31
Зураг 2. 27. Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, 2010-2019 он .....	31
Зураг 2. 28. Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшин, насны бүлгээр, 2010, 2019 он	32
Зураг 2. 29. Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшин, бүсээр, 2010, 2019 он.....	32
Зураг 2. 30. Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшин, аймаг, нийслэлээр, 2019 он...	33
Зураг 3. 1. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь, 2012-2019 он .....	35
Зураг 3. 2. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь, зорилтот насны ангиллаар, 2019 он.....	37
Зураг 3. 3. Үтрээн дурангийн шинжилгээний үзүүлэлт, 2012-2019 .....	37
Зураг 3. 4. Хорт хавдрын өвчлөлийн оношлогдох үеийн үе шат, дүнд эзлэх хувиар, 2010- 2019 он .....	38
Зураг 3. 5. Хорт хавдрын оношлогдох үеийн үе шат, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2010, 2019 он .....	39
Зураг 3. 6. Хорт хавдрын хяналт, зонхилон тохиолдох төрөл, хүйс, дүнд эзлэх хувиар, 2019 он .....	39
Зураг 3. 7. Хорт хавдрын хяналтад орсон, 5-аас дээш .....	40
Зураг 3. 8. Хавдрын ор (100000 хүнд ногдох), 2010-2019 он.....	41

Зураг 3. 9. Хавдар өвчнөөр эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн түвшин (10000 хүнд ногдох), 2010-2019 он .....	42
Зураг 4. 1. Хоргүй хавдар өвчин, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он .....	44
Зураг 4. 2. Хоргүй хавдар өвчин, 10000 хүнд ногдохоор, аймгаар, 2015, 2019 он.....	45
Зураг 4. 3. Хоргүй хавдрын өвчлөлийн түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019.....	45
Зураг 4. 4. Хоргүй хавдрын түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019 ...	46
Зураг 4. 5. Архаг гепатит өвчин, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он.....	47
Зураг 4. 6. Архаг гепатит өвчин, 10000 хүн амд ногдохоор, аймгаар, 2015, 2019 он .....	47
Зураг 4. 7. Архаг гепатит өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019.....	48
Зураг 4. 8. Архаг гепатит өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019 он .....	48
Зураг 4. 9. Элэгний хатуурал өвчин, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он .....	49
Зураг 4. 10. Элэгний хатуурал өвчин, 10000 хүн амд ногдохоор, аймаг, нийслэлээр, 2019 он.	49
Зураг 4. 11. Элэгний хатуурал өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он .....	50
Зураг 4. 12. Элэгний хатуурал өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019 он .....	50
Зураг 4. 13. Элэгний хордлогот өвчин, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015 он, 2019 он .....	51
Зураг 4. 14. Элэгний хордлогот өвчин, 10000 хүн амд ногдохоор, аймаг, нийслэлээр, 2019 он	51
Зураг 4. 15. Элэгний хордлогот өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он .....	52
Зураг 4. 16. Элэгний хордлогот өвчний түвшин (10000 хүнд ногдох), хүйс, насны бүлгээр, 2015, 2019 он .....	52
Зураг 4. 17. Ходоод, гэдэсний шархлаа өвчин, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он.	53
Зураг 4. 18. Ходоод гэдэсний шархлаа өвчин, 10000 хүн амд, аймаг, нийслэлээр, 2019 он.....	53
Зураг 4. 19. Ходоод, гэдэсний шархлаа өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он .....	54
Зураг 4. 20. Ходоод, гэдэсний шархлаа өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр 2015, 2019 он.....	54
Зураг 4. 21. Ходоод гэдэсний үрэвсэлт өвчин, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он..	55
Зураг 4. 22. Ходоод, гэдэсний үрэвсэлт өвчин, 10000 хүнд ногдохоор, аймаг, нийслэлээр, 2019 он .....	55
Зураг 4. 23. Ходоод, гэдэсний үрэвсэлт өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он .....	56
Зураг 4. 24. Ходоод, гэдэсний үрэвсэлт өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019 он.....	56
Зураг 4. 25. Уушгины архаг бөглөрөлт өвчин, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он..	57
Зураг 4. 26. Уушгины архаг бөглөрөлт өвчин, 10000 хүнд ногдохоор, аймаг, нийслэлээр, 2019 он .....	57
Зураг 4. 27. Уушгины архаг бөглөрөлт өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019 он.....	58
Зураг 4. 28. Уушгины архаг бөглөрөлт өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019 он.....	58
Зураг 4. 29. Уушгины тоосжилт өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он .....	59
Зураг 4. 30. Уушгины тоосжилт өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019 он .....	59
Зураг 4. 31. Уушгины тоосжилт өвчний түвшин (10000 хүнд ногдох), бүсээр, 2015, 2019 он ..	60
Зураг 4. 32. Уушгины тоосжилт өвчний түвшин (10000 хүнд ногдох), аймаг, нийслэлээр, 2019 он .....	60
Зураг 4. 33. Улаан хоолойн сөргөө өвчин, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он.....	61



Зураг 4. 34. Улаан хоолойн сөргөө өвчин, 10000 хүн амд ногдохоор, аймаг, нийслэлээр, 2019 он .....	61
Зураг 4. 35. Улаан хоолойн сөргөө өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он .....	62
Зураг 4. 36. Улаан хоолойн сөргөө өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019 он .....	62
Зураг 4. 37. Умайн хүзүүний шархлаа өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он .....	63
Зураг 4. 38. Умайн хүзүүний шархлаа ба шамраас, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он .....	63
Зураг 4. 39. Умайн хүзүүний шархлаа ба шамраас, 10000 хүнд ногдохоор, аймгаар, 2019 он ..	64
Зураг 4. 40. Умайн хүзүүний дисплази, 10000 хүнд ногдохоор, насны бүлгээр, 2015, 2019 он ..	64
Зураг 4. 41. Умайн хүзүүний дисплази, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он .....	65
Зураг 4. 42. Умайн хүзүүний дисплази, 10000 хүнд ногдохоор, аймгаар, 2019 он .....	65
Зураг 5.1. Хүн амын нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), зонхилон тохиолдох өвчний төрлөөр, 2010-2019 он.....	67
Зураг 5. 2. Хорт хавдрын шалтгаант нас баралт, 10000 хүнд амд, 2010-2019 он .....	70
Зураг 5.3. Хорт хавдрын шалтгаант нас баралт, оношлогдсоноос хойш амьдарсан хугацаагаар, 2010-2019 он .....	70
Зураг 5. 4. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, хүйсээр, 2010-2019 он .....	71
Зураг 5. 5. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, насны бүлгээр, 2010, 2019 он .....	71
Зураг 5. 6. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, насны бүлэг, хүйсээр, 2010, 2019 он.....	71
Зураг 5. 7. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, өвчний төрөл, хүйсээр, 2019 он.....	72
Зураг 5. 8. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, бүсээр, 2010, 2019 он .....	72
Зураг 5. 9. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, аймаг, нийслэлээр, 2019 он .....	73
Зураг 5. 10. Хорт хавдрын шалтгаант нас баралтын дүнд эзлэх хувь, зонхилох өвчний төрлөөр, 2010-2019 он .....	73
Зураг 5. 11. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, зонхилох өвчний төрлөөр, 2010-2045 он .....	74
Зураг 5. 12. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, зонхилох өвчний төрлөөр, 2010-2045 он .....	75
Зураг 5. 13. Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт, (10000 хүнд ногдох) 2010-2019 он ..	75
Зураг 5. 14. Элэгний хорт хавдрын нас баралт, анх оношлогдсоноос хойших амьдарсан хугацаа, хувиар, 2010-2019 он .....	76
Зураг 5. 15. Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), хүйсээр, 2010-2019 он. ....	76
Зураг 5. 16. Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2010-2019 он .....	77
Зураг 5. 17. Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2010, 2019 он .....	77
Зураг 5. 18. Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), бүсээр, 2010, 2019 он .....	78
Зураг 5. 19. Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, аймаг, нийслэлээр, 2019 он .....	78
Зураг 5. 20. Ходоодны хорт хавдрын шалтгаант нас баралт, 2010-2019 он .....	79
Зураг 5. 21. Ходоодны хорт хавдрын нас баралт, анх оношлогдсоноос хойших амьдарсан хугацаа, хувиар, 2010-2019 он .....	79

Зураг 5. 22. Ходоодны хорт хавдрын нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2010, 2019 он.....	80
Зураг 5. 23. Ходоодны хорт хавдрын нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2010, 2019 он.....	80
Зураг 5.24. Ходоодны хорт хавдрын нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), бүсээр, 2010, 2019 он .....	81
Зураг 5. 25. Ходоодны хорт хавдрын нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), аймаг, нийслэлээр, 2019 он .....	81
Зураг 5. 26. Уушгины хорт хавдрын нас баралт, 10000 хүнд ногдох түвшин, 2010-2019 он.....	82
Зураг 5. 27. Уушгины хорт хавдрын нас баралт, анх оношлогдсоноос хойш амьдарсан хугацаа, хувиар, 2010-2019 он.....	82
Зураг 5. 28. Уушгины хорт хавдрын нас баралтын түвшин, насны бүлгээр, 2010, 2019 он.....	83
Зураг 5. 29. Уушгины хорт хавдрын нас баралтын түвшин, хүйс, насны бүлгээр, 2010, 2019 он .....	83
Зураг 5. 30. Уушгины хорт хавдрын нас баралтын түвшин, хүйс, насны бүлгээр, 2010, 2019 он .....	84
Зураг 5. 31. Уушгины хорт хавдрын нас баралтын түвшин, аймаг, нийслэлээр, 2019 он .....	84
Зураг 5. 32. Улаан хоолойн хорт хавдрын нас баралт, 10000 хүнд ногдох түвшин, 2010-2019 он .....	85
Зураг 5. 33. Улаан хоолойн хорт хавдрын нас баралт, анх оношлогдсоноос хойш амьдарсан хугацаа, хувиар, 2010-2019 он .....	85
Зураг 5. 34. Улаан хоолойн хорт хавдрын нас баралтын түвшин, насны бүлгээр, 2010, 2019 он .....	86
Зураг 5. 35. Улаан хоолойн хорт хавдрын нас баралтын түвшин, хүйс, насны бүлгээр, 2010, 2019 он .....	86
Зураг 5. 36. Улаан хоолойн хорт хавдрын нас баралтын түвшин, бүсээр, 2010, 2019 он.....	86
Зураг 5. 37. Улаан хоолойн хорт хавдрын нас баралтын түвшин, аймаг, нийслэлээр, 2019 он .....	87
Зураг 5. 38. Умайн хүзүүний хорт хавдрын нас баралт, 2010-2019 он .....	87
Зураг 5. 39. Умайн хүзүүний хорт хавдрын нас баралт, анх оношлогдсоноос хойш амьдарсан хугацаа, хувиар, 2010-2019 он .....	88
Зураг 5. 40. Умайн хүзүүний хорт хавдрын нас баралтын түвшин, насны бүлгээр, 2010, 2019 он .....	88
Зураг 5. 41. Умайн хүзүүний хорт хавдрын нас баралтын түвшин, бүсээр, 2010, 2019 он .....	89
Зураг 5. 42. Умайн хүзүүний хорт хавдрын нас баралтын түвшин, аймаг, нийслэлээр, 2019 он .....	89



## ХУРААНГУЙ

- ❖ Амбулаторид бүртгэгдсэн хавдрын тархалтын түвшинг (10000 хүнд ногдох) сүүлийн 10 жилийн байдлаар харвал 2019 онд улсын хэмжээнд 212 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 34-өөр, өмнөх оноос 11-ээр тус тус нэмэгджээ.
- ❖ Хүн амын хавдар өвчний тархалтын түвшинг насны бүлгээр, сүүлийн 10 жилийн дунджаар харвал бүх насанд тохиолдож байгаа хэдий ч 20-44 насанд нийт тохиолдлын 24.3 хувь, 45-аас дээш насанд 71.3 хувийг эзэлж байна. Энэхүү үзүүлэлтийг насны бүлэг, хүйсээр харвал 15-54 насанд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 17-338-аар их, 55-59, 65-аас дээш насанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 7-185-аар их байна.
- ❖ Монгол Улсад нийт хорт хавдрын шинэ өвчлөлийн түвшин 2001-2014 оны дунджаар 15.7 байсан бол сүүлийн 2015-2019 оны дунджаар 18.8 болж, 3.1-ээр өссөн бол 2041-2045 оны дунджаар 29.2 болж, 10.5-аар өсөхөөр байна. Улсын хэмжээнд 2019 онд хорт хавдрын шинэ тохиолдол 6045 бүртгэгдсэн нь сүүлийн 10 жилийн дунджаас 734-өөр, өмнөх оноос 232-оор тус тус нэмэгдсэн байна. Хорт хавдраар шинээр өвчлөгчдийн 51.7 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.
- ❖ 2010-2019 онд нийт 54607 хорт хавдрын шинэ тохиолдол оношлогдсоны 20200 хүн буюу 37 хувийг элэгний хорт хавдар эзэлж байна. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин 2001-2014 оны дунджаар 5.9 байсан бол сүүлийн 5 жилийн дунджаар 7.2 болж, 1.3-аар өсч, 2041-2045 оны дунджаар 10.9 болж өсөх таамаглал гарсан. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин 2019 онд 6.8 болж, сүүлийн 10 жилийн дундаж, өмнөх оноос тус тус 0.1-ээр буурсан байна. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин 2019 онд бүх бүсэд улсын дунджаас 0.6-6.4-өөр их болсон байна. Энэ үзүүлэлт зүүн бүс үүний дотор Хэнтий аймагт хамгийн өндөр байна.
- ❖ Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшин сүүлийн 5 жилийн дунджаар 3.0 болж, өмнөх 14 жилийн дунджаас 0.6-гаар өссөн бол 2041-2045 оны дунджаар 6.1 болж, 2 дахин өсөхөөр байна. Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшин 2019 оны байдлаар эрэгтэйчүүдийнх 4.6 болж, эмэгтэйчүүдээс 2.2 дахин, 2010 оныхоос 1.6-гаар их байна. Насны бүлгээр харвал 50-аас дээш насныхан 82.7 хувийг эзэлж, 2010 оныхоос 10.2 пунктээр нэмэгдсэн байна. Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшин 2019 онд хангайн бүсэд улсын дундажтай адил бусад бүсэд улсын дунджаас 0.2-1.1-ээр их байна. Баруун бүс үүний дотор Увс аймагт өвчлөлийн түвшин хамгийн өндөр байна.
- ❖ Уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшин сүүлийн 5 жилийн дунджаар 1.5 болж, өмнөх 14 жилийн дунджаас 0.2-оор нэмэгдсэн байна. 2041-2045 онд энэ үзүүлэлт 3.8 болж, сүүлийн 5 жилийн дунджаас 2.6 дахин нэмэгдэхээр байна. Уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшин 2019 онд 1.5 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 0.1-ээр нэмэгдэж, өмнөх оноос 0.1-ээр буурсан байна. Харин уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшин 2019 оны байдлаар харвал эрэгтэйчүүдийнх 2.5 болж, 2010 оныхоос 0.2-оор, эмэгтэйчүүдийнх 0.6 болж, 0.1-ээр тус тус нэмэгдсэн байна. Энэ үзүүлэлтийг насны бүлгээр харвал 91.2 хувь нь 45-аас дээш насныхан байгаа нь 2010 оныхоос 3.3 пунктээр нэмэгдсэн байна. Уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшин 2019 онд баруун бүсэд улсын дундажтай адил, бусад бүсэд улсын дунджаас 0.4-1.1-ээр их байна. Зүүн бүс үүний дотор Сүхбаатар аймагт өвчлөлийн түвшин хамгийн өндөр байна.

- ❖ Улаан хоолойн хавдрын өвчлөл сүүлийн 5 жилийн дунджаар 1.2 болж, өмнөх 14 жилийн дундажтай адил, 2041-2045 оны дунджаар 1.5 болж, нэмэгдэх хандлагатай байна. Улаан хоолойн хорт хавдрын өвчлөлийн түвшин 2019 онд 1.1 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 0.1-ээр тус тус буурсан байна. Улаан хоолойн өвчлөлийн түвшинг 2019 оны байдлаар хүйсээр харвал эрэгтэйчүүдийнх 1.2 болж, эмэгтэйчүүдээс 0.2-оор их, 2010 оныхтой адил түвшинд байна. Өвчлөлийн түвшин баруун бүсийн Увс аймагт хамгийн өндөр байна.
- ❖ Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшин сүүлийн 5 жилийн дунджаар 1.2 болж, өмнөх 14 жилийн дунджаас 0.1-ээр буурч, 2041-2045 онд 1.1 болж, буурах таамаглал гарсан байна. Өвчлөлийн түвшин 2019 онд 1.0 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 0.4-өөр, өмнөх оноос 0.2-оор тус тус буурсан байна. Энэ нь улсын хэмжээнд 2012 оноос эхлэн умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийг зорилтот насны эмэгтэйчүүдэд хийж эхэлсэнтэй холбоотой юм.
- ❖ 2019 оны байдлаар улсын хэмжээнд умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 88493 эмэгтэй хамрагдаж, энэ нь хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн 53.6 хувийг эзэлж, харин нийслэл Улаанбаатар хотод улсын болон аймгийн дунджаас байнга бага байгаа нь анхаарал татаж байна. Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь 2018-2019 онд хамгийн өндөр хамрагдалттай Сүхбаатар аймаг байгаа бол, хамгийн бага хамрагдалтай нь Орхон аймаг байна. Нас ахих тусам хорт хавдраар өвчлөх эрсдэл нэмэгддэг атал умайн хүзүүний хорт хавдрын илрүүлэг үзлэгт 50-аас дээш насны эмэгтэйчүүдийн хамрагдалт бусад насны ангилалтай харьцуулахад бага байна.
- ❖ Хорт хавдрын шинэ өвчлөлийн оношлогдсон үе шатыг сүүлийн 10 жилийн дунджаар харвал 10 хүний 2 нь эрт үедээ, 8 нь хожуу үедээ оношлуулж байна. 2010-2019 оны байдлаар хорт хавдар оношлогдсон хүн амын 77 хувь нь өвчнийхөө III, IV үе шатанд оношлогдож, хорт хавдрын шалтгааны улмаас нас барсан нийт хүн амын 73 хувь нь анх оношлогдсоноосоо хойш 1 жил хүртэлх хугацаанд амьдарсан байна. 2019 онд хорт хавдраар шинээр өвчлөгчдийн 27.5 хувь нь эрт үедээ оношлогдож, сүүлийн 10 жилийн дунджаас 4.7 пунктээр, өмнөх оноос 3.6 пунктээр тус тус нэмэгдсэн байна.
- ❖ Монгол Улсын Засгийн газраас “Халдварт бус өвчинтэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд элэгний хорт хавдрын эрт үеийн илрүүлгийн хувийг 2019 онд 20.7 болгох зорилт тавьсан нь 2019 онд 22.5 болж, умайн хүзүүний хорт хавдрыг эрт шатанд илрүүлэх хувийг 2019 онд 42.5 болгох зорилт 2019 онд 55.3 болж тус тус биелсэн байна.
- ❖ Монгол Улсад 2019 оны жилийн эцэст 19.9 мянган хүн хорт хавдрын улмаас аймаг дүүргийн хавдар судлаач их эмчийн хяналтад байгаагийн 7.0 (35.5%) мянга нь эрэгтэй, 12.9 (64.5%) мянга нь эмэгтэйчүүд байна. Улсын хэмжээнд хорт хавдрын хяналтад хамрагдалтын хувь 2019 онд 62.5 болж, 2010 оныхоос 17.0 пунктээр буурсан байна. Хорт хавдрын хяналтад байгаа нийт хүмүүсийн 37.0 хувь нь 5, түүнээс дээш жил амьдарсан байна. Зонхилон тохиолдох хорт хавдрын хяналтад байгаа хүмүүсийн 5, түүнээс дээш жил амьдарсан хувь ходоодны хорт хавдрын өвчлөл хамгийн их 32.0, хамгийн бага нь элэгний хорт хавдрынх 21.0 байна.
- ❖ Хавдар өвчний улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн түвшин 2019 онд 32 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 6-гаар, өмнөх оноос 4-өөр тус тус нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд хорт хавдраар шинээр өвчлөгчдийн эмчилгээний төрлийг харвал нийт хорт хавдрын өвчлөлийн 53.5 хувь нь хөнгөвчлөх эмчилгээ, тусламж авсан байна.

- ❖ Энэхүү судалгаагаар хавдрын тэргүүлэх 5 шалтгааны зарим урьдал өвчнүүд болох хоргүй хавдар, вирусийн шалтгаант элэгний архаг үрэвсэл, элэгний хатуурал, ходоодны шархлаа, уушгины архаг бөглөрөлт өвчин, улаан хоолойн шархлаа, сөөргөө өвчин, умайн хүзүүний шархлаа ба шамраас, умайн хүзүүний дисплази зэрэг амбулаториор бүртгэгдсэн өвчнийг, давхардсан тоогоор, байршлаар, насны бүлэг, хүйсээр харьцуулан дүн шинжилгээ хийсэн.
- ❖ Улсын хэмжээнд хоргүй хавдар өвчний түвшин 2019 онд 73 болж, 2015 оныхоос 1.5 дахин нэмэгджээ. Хоргүй хавдрын өвчлөлийн түвшин 40-өөс дээш насныханд хамгийн их бөгөөд 2015 онд дунджаар 110.5 болж, бусад насныхнаас 4.2 дахин их байсан бол 2019 онд 151.8 болж, 2015 оныхоос 41.3-аар нэмэгдэж, бусад насныхаас 3.6 дахин их болжээ. Өвчлөлийн түвшинг хүйсээр харвал 2019 онд эмэгтэйчүүдийнх 110.0 болж, эрэгтэйчүүдээс 3.0 дахин их, 2015 оныхоос 1.5 дахин, эрэгтэйчүүдийнх 36.2 болж, 1.6 дахин тус тус нэмэгджээ.
- ❖ Улсын хэмжээнд элэгний архаг хепатит өвчин элэгний нийт өвчлөлд хамгийн их хувийг эзэлж 2015 онд 38.3 хувь байсан бол, 2019 онд 45.3 болж 10.3 пунктээр нэмэгджээ. Архаг хепатит өвчний түвшинг насны бүлгээр харвал 2019 онд 2015 онтой харьцуулахад бүх насанд 1.1-4.3 дахин нэмэгдэж үүнээс 0-9 насанд дунджаар хамгийн их буюу 3.2 дахин нэмэгдсэн байна. Өвчлөлийн түвшин 35-39 насанд хамгийн их бөгөөд 2019 онд дунджаар 227.9 болж, бусад насныхны дунджаас 7.8 дахин, 2015 оныхоос 1.3 дахин их байна. Архаг хепатит өвчний түвшинг хүйсээр харвал 2019 онд эмэгтэйчүүдийнх 104.7 болж, эрэгтэйчүүдээс 22.5-аар их, 2015 оныхоос 30.4-өөр нэмэгдсэн байна.
- ❖ Уушгины архаг бөглөрөлт өвчин 2019 онд улсын хэмжээнд болон Улаанбаатар, аймаг, бүсийн түвшинд 2015 оноос 2 дахин нэмэгджээ. Хүйсийн хувьд 2015 онд эрэгтэй 44 хувь, эмэгтэй 56 хувь, 2019 онд эрэгтэй 43 хувь, эмэгтэй 57 хувь байна.
- ❖ Уушгины тоосжилт өвчний түвшин 2019 онд 0.8 болж, 2015 оныхоос 0.2-оор нэмэгдсэн байна. Өвчлөлийн түвшинг насны бүлгээр харвал 55-аас дээш насныхан бусад насныхнаас 2 дахин их өвчилж байна. 2015 онтой харьцуулахад 2019 онд эрэгтэйчүүдийн өвчилсөн нас 10 насаар хойшилж, эмэгтэйчүүдийнх 5 насаар залуужсан байна. Уушгины тоосжилт өвчний түвшин 2015 онтой харьцуулахад 2019 онд баруун бүсэд 0.1-ээр буурч, бусад бүсэд 0.1-3.8-аар нэмэгдсэн байна. Өвчлөлийн түвшин 2019 онд баруун болон хангайн бүсэд улсын дунджаас 0.5-0.7-гоор бага, төвийн бүсэд адил, зүүн бүсэд 5.7-гоор их байна. Уушгины тоосжилт өвчний түвшин 2019 онд Орхон, Архангай, Увс, Говь-Алтай аймагт бүртгэгдээгүй, Дорнод, Сэлэнгэ, Төв, Булган, Говьсүмбэр, Хэнтий аймагт улсын дунджаас 0.1-15.9-өөр их, бусад аймаг, нийслэлд 0.1-0.7-гоор бага байна. Өвчлөлийн түвшин 2019 онд зүүн бүсийн Хэнтий аймагт хамгийн өндөр байна.
- ❖ Улаан хоолойн сөргөө өвчин улсын хэмжээнд 2019 онд 16.5 болж, 2015 оныхоос 5.4-өөр, бүх бүсэд 5.1-10.9-өөр нэмэгдсэн байна. 2015 онд өвчлөлийн түвшин бүх бүсэд улсын дунджаас 2.3-6.1-ээр бага байсан бол 2019 онд баруун бүсэд улсын дунджаас 3.3-аар их бусад бүсэд 1.9-6.3-аар бага болж өөрчлөгдсөн байна. Өвчлөлийн түвшин баруун бүсийн Увс аймагт хамгийн өндөр байна.

Өвчлөлийн түвшин 2019 онд бүх насны бүлэгт тохиолдож нас ахих тутам нэмэгдсээр 60-64 насанд 99.8 болж хамгийн их байна.

- ❖ Умайн хүзүүний шархлаа өвчний түвшин 2015 онд 12.2 байсан 2019 онд 4.7 болж, 2.6 дахин буурсан байна. Өвчлөлийн түвшинг насны бүлгээр харвал 2015 онд 25-64 насанд хамгийн их улсын дунджаас 1.3-2.3 дахин их байжээ. Энэ үзүүлэлт 2019 онд 25-59 насанд хамгийн их бөгөөд 2015 онтой харьцуулахад 1.9-3.7 дахин буурсан байна.
- ❖ Умайн хүзүүний дисплази өвчний түвшин 2015 онд улсын дунджаар 6.1 байсан бол 2019 онд 7.0 болж, 0.9-өөр нэмэгдсэн байна. Өвчлөлийн түвшинг насны бүлгээр харахад 15-аас дээш насны эмэгтэйчүүд өвчилж, үүний дотор 30-аас дээш насны эмэгтэйчүүд хамгийн их буюу улсын дунджаас 0.6-9.6-гаар их байна. Умайн хүзүүний дисплази өвчний түвшин 2015 онд төвийн бүсэд улсын дундажтай адил, бусад бүсэд улсын дунджаас 1.8-3.6-гаар бага байсан бол 2019 онд хангайн болон төвийн бүсэд улсын дунджаас 0.1-0.3-аар их бусад бүсэд 0.5-0.8-аар бага болжээ.
- ❖ Монгол Улс 100000 хүн амд ногдож байгаа хорт хавдрын өвчлөлийн түвшнээр дэлхийд өндөр, нас баралтаараа хамгийн өндөр улс юм. Монгол улсад 2010-2019 оны хооронд 38119 хүн хорт хавдрын шалтгаанаар нас барж нийт нас баралтын 22.8 хувийг эзэлж байна. 2019 онд хорт хавдрын нас баралтын 4801 тохиолдол бүртгэгдэж, сүүлийн 10 жилийн дунджаас 989 (25.9%)-өөр, өмнөх оноос 389 (8.8)-өөр тус тус нэмэгджээ.
- ❖ Хорт хавдраар нас барсан хүмүүсийн оношлогдсоноос хойш амьдарсан хугацааг сүүлийн 10 жилийн дунджаар харвал 73.1 хувь нь (10 хүний 7) 1 хүртэл, 22.9 хувь (10 хүний 2) нь 1-5 хүртэлх жил, 4.1 хувь (10 хүний 1) нь 5, түүнээс жил амьдарсан байна. 2019 онд хорт хавдартай хүний оношлогдсоноос хойших амьдарсан хугацаа сүүлийн 10 жилийн дунджаас нэмэгдсэн байна.
- ❖ Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин сүүлийн 10 жилийн дунджаар эрэгтэйчүүдийнх 15 болж, эмэгтэйчүүдээс 4-өөр их байна. 2019 онд эрэгтэйчүүдийнх 16 болж, эмэгтэйчүүдээс 2-оор их, сүүлийн 10 жилийн дунджаас 1-ээр нэмэгдэж өмнөх онтой адил түвшинд байна. Эмэгтэйчүүдийн хорт хавдрын нас баралтын түвшин 2019 онд 14 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 2-3-аар нэмэгджээ.
- ❖ Хорт хавдрын шалтгаант нас баралтын бүтцийг судалж үзэхэд сүүлийн 10 жилийн дунджаар элэг 41.9 хувь, ходоод 15.6 хувь, уушги 9.4 хувь, улаан хоолой 7.6 хувь, умайн хүзүү 3.8 хувь, хөх 1.6 хувийг тус тус эзэлж байна.
- ❖ Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшинг 2019 оны байдлаар, зонхилох өвчний төрлөөр харвал эрэгтэйчүүдийн хувьд элэг, ходоод, уушги, улаан хоолой, нойр булчирхайн өвчлөл тэргүүлж байна. Эмэгтэйчүүдийн хувьд элэг, ходоод, умайн хүзүү, улаан хоолой, хөх, уушгины хавдрын шалтгаант нас баралт тэргүүлж байна.
- ❖ Хорт хавдрын нас баралтыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийг үр дүнтэй болгон, сайжруулахгүй, хүн амын өсөлтийн түвшин энэ хэвээр байна гэж үзвэл 2045 он гэхэд нийт хорт хавдрын нас баралтын түвшин 3 дахин өсөхөөр байна. Тухайлбал:

- Элэгний хорт хавдрын нас баралтын түвшин 2010-2014 оны дунджаар 5.2 байсан бол сүүлийн 5 жилийн дунджаар 5.7 болж, 0.5-аар, 2045 он гэхэд 16.6 болж одоогийнхоос мөн л 3 дахин өсөхөөр байна.
- Хорт хавдрын нас баралтын 2 дахь шалтгаан болсон ходоодны хорт хавдрын нас баралтын түвшин 2010-2014 оны дунджаар 1.9 байсан бол сүүлийн 5 жилийн дунджаар 2.2 болж, 0.3-аар нэмэгдэж, 2045 он гэхэд 3.8 болж өсөх хандлагатай байна.
- Уушгины хорт хавдрын шалтгаант нас баралт 2010-2014 оны дунджаар 1.2 байсан бол сүүлийн 5 жилийн дунджаар 1.3 болж нэмэгдсэн байна. Энэ үзүүлэлт 2045 он гэхэд 3.1 болж өсөхөөр байна.
- Умайн хүзүүний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин 2010-2014 оны дунджаар 0.5 байсан бол сүүлийн 5 жилийн дунджаар өөрчлөгдөөгүй байна. Монгол Улсын хэмжээнд умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж өвчлөл буурсан ч нас баралтын түвшин буурахгүй байна. Энэ хэвээр нас баралтын түвшинг бууруулах бодлого хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхгүй бол 2045 он гэхэд нас баралтын түвшин 1.1 болж өсөхөөр байна.



## БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

### Дэлхийн улс орнуудын өвчлөл, нас баралтын хандлагын тойм, хөтөлбөр

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас гаргасан сүүлийн үеийн мэдээллээр 2030 он гэхэд дэлхий даяар 13.2 сая хүн хорт хавдраар нас барна гэж таамаглаж байсан бол дэлхийн хүн амын өсөлт тасралтгүй нэмэгдэж, үүнийг дагаад хорт хавдрын өвчлөл ч нэмэгдсээр 2030 он гэхэд 20.3 сая болж нэмэгдэх төлөвтэй гэсэн таамаглал байна.<sup>1</sup>

ДЭМБ-ын мэдээлснээр 2016 онд дэлхийн хэмжээнд 41 сая хүн халдварт бус өвчний улмаас нас барсан нь нийт нас баралтын 71 хувьтай тэнцэж байна. Нас баралтын тэргүүлэх 4 тохиолдол нь зүрх судасны өвчлөл (17.9 сая хүн), хорт хавдар (9.0 сая хүн), амьсгалын замын архаг өвчин (3.8 сая хүн), чихрийн шижин (1.6 сая хүн) өвчин байна.

Дэлхийн бага болон дунд орлоготой орнуудад 2016 онд 15 сая нас баралт бүртгэгдсэний 85 хувь нь халдварт бус өвчний шалтгааны улмаас нас баржээ. Иймээс эдгээр улс орнуудад ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад илүү үр дүнтэй арга хэмжээ авах, одоо байгаа ХБӨ-тэй хүмүүсийн эрүүл мэндийг хянах, оношилгоо, эмчилгээ, нөхөн сэргээх, хөнгөвчлөх зэрэг эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

Дэлхийн хэмжээнд 2018 оны байдлаар нас баралтын шалтгааны хоёрдугаарт хорт хавдар орсон бөгөөд 9.6 сая хүн буюу 6 хүн тутмын 1 нь хорт хавдрын улмаас нас барсан байна. Хорт хавдрын нас баралтын хамгийн түгээмэл шалтгаан нь уушги (1.76 сая хүн), колоректал (862.0 мянга), ходоод (783.0 мянга), элэг (782.0 мянга), хөхний (627.0 мянга) хорт хавдар байна.

Дэлхий даяар тамхи, согтууруулах ундааны хэрэглээ, эрүүл бус хооллолт, хөдөлгөөний идэвхгүй байдал зэрэг нь хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл болох нь тогтоогдсон.

Хорт хавдар нь зөвхөн ХБӨ бус мөн халдварт өвчин юм. Учир нь бага болон дунд орлоготой улс, орнуудад хорт хавдрын 25 хүртэлх хувь нь элэгний В, С (гепатоцеллюлозын хавдар), хүний папиллома вирус (HPV) (умайн хүзүүний хорт хавдар), элэгний флюкоз, систозомиаз (цэсний хүүдий, давсагны хорт хавдар) зэрэг халдварт өвчнүүдээс хамааралтай байдаг.<sup>2</sup>

ДЭМБ-аас хорт хавдрын тархалтыг бууруулахын тулд эрсдэлт хүчин зүйлээс зайлсхийх, одоо байгаа нотолгоонд суурилан урьдчилан сэргийлэх стратегиудыг хэрэгжүүлснээр хорт хавдрын тархалтыг 30-50% бууруулах боломжтой гэсэн тооцоолол гаргажээ. Хорт хавдрыг эрт илрүүлэн, эмчилснээр бүрэн эдгэрэх боломжтой байдаг.

Хорт хавдрыг эрт илрүүлэн оношлоход хүн амын хавдрын талаарх мэдлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол давтамжтай үзүүлэх нь чухал ач холбогдолтой. ДЭМБ-ын 70 дахь удаагийн хурлаар дэлхийн 194 орны засгийн газар нэгдэж, "Хорт хавдрын эсрэг шийдэл" тогтоолыг баталсан. Уг тогтоолд дэлхийн болон үндэсний түвшинд улс орнуудын засгийн газар, олон улсын байгууллагуудаас хорт хавдраас урьдчилан сэргийлэх, хянахтай холбоотой асуудалд анхаарал хандуулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг нь улс орнууд нэн тэргүүнд тавих, нийгмийн эрүүл мэндийн чухал асуудал гэж заасан.<sup>3</sup>

Тогтвортой хөгжлийн зорилтын 3.4-т 2030 он гэхэд халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх замаар халдварт бус өвчнөөс үүдэлтэй цаг бусаар нас барах

явдлыг гуравны нэгээр бууруулах, 3.8-д хүн бүрт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгох, эрүүл мэндтэй холбоотой санхүүгийн эрсдэлээс хамгаалж, нэн шаардлагатай, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг аюулгүй, үр дүнтэй, чанартай, боломжийн үнэтэй зайлшгүй шаардлагатай эм, вакцинаар хангах гэж тусгасан байдаг.

Дэлхийн улс орнуудын 70-аас дээш хувь нь хорт хавдрын хяналтын үндэсний хөтөлбөртэй боловч тогтвортой үйл ажиллагаа явуулж хөтөлбөрөө бүрэн хэрэгжүүлж чаддаггүй. Аливаа хөтөлбөр төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн бодлого боловсруулагч, эрдэм шинжилгээний байгууллага, эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд, иргэний нийгэм, өвчтөнүүд, аж үйлдвэрийн салбарын бүхий л оролцоо шаардлагатай юм.<sup>4</sup>

Бага болон дунд орлоготой улс орнуудын эрүүл мэндийн тогтолцоо нь өсөн нэмэгдэж буй ачааллыг зохицуулахад сайн бэлтгэгдээгүй бөгөөд одоогийн төсвийн хуваарилалт нь хангалтгүй байна.

Дэлхийн хэмжээнд хорт хавдрын өвчлөлийн 60 орчим хувь нь бага болон дунд орлоготой улсад тохиолддог боловч эдгээр улсууд хорт хавдрын зардалд дөнгөж 5 хувийг зарцуулдаг. Хорт хавдрын эмчилгээнд бага нөлөөтэй, өндөр өртөгтэй эмчилгээний зардлыг бууруулснаар нөөцийг хорт хавдрын чухал эмчилгээний багцад хямд өртөгтэйгөөр дахин хуваарилах боломжтой болно гэж судлаачид тодорхойлсон.<sup>5</sup>

### **Монгол Улсын хэмжээнд хавдрыг хяналтад авсан түүх, одоо хэрэгжиж буй бодлого хөтөлбөр**

1961 онд ЭХЯ-ны 24 дүгээр тогтоолоор “Улсын цацраг туяа эмнэлэг” нэртэй, 45 ортой, үндэсний 5 эмчтэй, ЗХУ-ын 4 мэргэжилтэнтэй байгуулагджээ. Эрүүлийг хамгаалах яамны сайдын 1971 оны 160 дугаар тушаалаар хорт хавдрын өвчлөл, нас баралтыг улсын хэмжээгээр заавал бүртгэх журам батлагдсан.

“Хорт хавдартай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах” тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 3 сарын 80 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, хорт хавдартай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хавдар өвчнийг эрт илрүүлэн, оношлох зорилгоор тус төвийн нарийн мэргэжлийн эмч нарийн бүрэлдэхүүнтэй урьдчилан сэргийлэх үзлэгийн бригадыг 1997 оны 5 сарын 16-наас эхлэн зохион байгуулж нийслэлийн дүүргүүдэд тогтмол ажиллуулж эхэлжээ.

1998 оноос эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын алба ажиллаж, улмаар удирдлагын албанд статистик мэдээллийн хэсгийг нэгтгэсэн нь бүртгэл нэг шатаар ахисан юм. 2017 оноос хорт хавдрын бүртгэл тандалт-эрт илрүүлгийн алба байгуулсан байна.

Эрүүл мэндийн салбарын хүрээнд хэрэгжүүлж буй томоохон бодлого, хөтөлбөрүүд:

- Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого (2017-2021);
- Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд (2015-2030);
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030;
- “Халдварт бус өвчинтэй тэмцэх” үндэсний хөтөлбөр (2017-2030);
- “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр (2017-2020);



Хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн ардаа урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчныг бүрдүүлэх зорилгоор анх Монгол Улсын Их Хурлаас 2004 оны 21 дүгээр тогтоолоор “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого” (2004-2015)-ыг хэрэгжүүлсэн бөгөөд энэхүү хөтөлбөрийг үргэлжлүүлэн 2016 оны 5 дугаар сард Засгийн газрын тогтоолоор шинэчлэн (2016-2025 он) баталсан.

Мянганы хөгжлийн зорилтын үргэлжлэл болгон Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг 2015 оны 9 дүгээр сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Тогтвортой хөгжлийн дээд хэмжээний чуулганаар баталсан.

Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ыг 2016 оны 2 дугаар сард Улсын Их Хурлын 19 дүгээр тогтоолоор баталсан. Энэхүү үзэл баримтлалын 2.2.2 Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцоог бий болгох зорилгын зорилт 3-т “Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан, хорт хавдрын нас баралтын түвшинг 2016-2020 он гэхэд 10.5 болгох, цаашлаад 2030 он гэхэд 8 болгоно гэж заасан.

### **Судалгааны зорилго**

Хүн амын хавдрын өвчлөл, нас баралтын өнөөгийн байдлыг судлах, хүн амын хавдрын өвчлөлийн зонхилох шалтгаан болж буй хавдрын урьдал өвчин, нас баралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт шаардлагатай тоон мэдээллийг бий болгоход оршино.


### **Арга зүй**

Хүн амын өвчлөлийн сүүлийн 10 жилийн (2010-2019 он) мэдээллийн баазад дүн, шинжилгээ хийж судалсан. Судалгаанд 2010-2019 оныг хамарсан шинээр бүртгэгдсэн хавдар, халдварт бус өвчнийг мэдээлэх карт, эмнэлгээс гарагчийн карт, нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ, мэдээлэх хуудас болон статистик тайлан, мэдээг ашигласан.

Мэдээний сангаас мэдээлэл цуглуулан, баримтын судалгааны аргаар судалгааг хийсэн. Сүүлийн 20 жилийн байдлаарх өвчлөлийн өсөлт, бууралтын хандлага, Үндэсний статистикийн хорооноос тооцсон хүн амын 2045 он хүртэлх хэтийн тооцоог ашиглан өвчлөгчдийн түвшинг зонхилон тохиолдох өвчний төрлөөр 2045 он хүртэлх таамаглалыг эксел программын trendline оруулж өнгөрсөн 20 жилийн хугацааны өсөлт, бууралттай хамгийн ойролцоо тэгшитгэлийн загварыг ашиглан тооцсон.

## БҮЛЭГ 2. ХАВДРЫН ӨВЧЛӨЛ

### Хавдрын тархалт




### Хорт хавдраар шинээр өвчлөгчдийн хүйс, нас, 2010-2019 оны дундаж




Хорт хавдартай **10** хүний **5** нь эрэгтэй, **5** нь эмэгтэй

Хорт хавдартай **10** хүний **9** нь 40-өөс дээш настай




### Хорт хавдраар шинээр өвчлөгчид, өвчний төрөл, 2010-2019 оны дундаж, хувиар

#### Насанд хүрэгчид



#### 0-19 насны хүүхэд



## Хавдрын тархалт


Халдварт бус өвчлөл нь хүн амын зан үйл, нийгмийн хүчин зүйлээс ихээхэн шалтгаалдаг бөгөөд урьдчилан сэргийлж, эрт үед нь илрүүлж эмчлэх боломжтой байдаг.

Манай улсын хүн амын өвчлөлийн хэв маягт 1990-ээд оноос эхлэн тархвар зүйн өөрчлөлт орж, хүн амын дунд халдварт бус өвчлөл, үүнээс шалтгаалсан нас баралт нэмэгдсээр байна.

Улсын хэмжээнд хортой ба хоргүй хавдар өвчин амбулаторид бүртгэгдсэн давхардсан тоогоор 2019 онд 67.7 мянга болж, нийт өвчлөлийн 1.9 хувийг, хортой хавдар 43.0 мянга бүртгэгдэж нийт хавдрын 63.5 хувийг эзэлж байна. Өвчний олон улсын 10 дугаар ангиллын дагуу 21 өвчний бүлгээр эрэмбэлэхэд хавдар өвчин 2019 оны байдлаар 14 дүгээрт, харин нийт нас баралтын шалтгааны 2 дугаарт орж байна.

Хавдрын тархалтын түвшинг (10000 хүнд ногдох) сүүлийн 10 жилийн байдлаар, харвал 2019 онд улсын хэмжээнд 212 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 34-өөр, өмнөх оноос 11-ээр тус тус нэмэгджээ.


Зураг 2. 1. Хавдар өвчний тохиолдол, 2010-2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-II

Хүн амын хавдар өвчний тохиолдлын түвшинг насны бүлгээр, сүүлийн 10 жилийн дунджаар харвал бүх насанд тохиолдож байгаа хэдий ч 20-44 насанд нийт тохиолдлын 24.3 хувь, 45-аас дээш насанд 71.3 хувийг эзэлж байна.

Зураг 2. 2. Хавдар өвчний тохиолдлын түвшин, хүйс, насны бүлгээр, 2019 он




Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-II

Амбулаторид бүртгэгдсэн хавдар өвчний түвшинг хүйсээр, насны бүлгээр харвал 0-14 насанд хүйсийн ялгаа бага, 15-аас дээш насанд 7-338 байна. Өөрөөр хэлбэл 15-54 насанд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 17-338-аар их, 55-59, 65-аас дээш насанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 7-185-аар их байна.

### Хорт хавдрын шинэ тохиолдол

Монгол Улсын хэмжээнд 2019 онд хорт хавдрын шинэ тохиолдол 6045 бүртгэгдсэн нь сүүлийн 10 жилийн дунджаас 734-өөр, өмнөх оноос 232-оор тус тус нэмэгдсэн байна.

Зураг 2. 3. Хорт хавдрын шинэ тохиолдол, 2010-2019 он




Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Хорт хавдрын шинэ тохиолдлын түвшин 2019 онд 19 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос тус тус 1-ээр нэмэгдсэн байна.

Хорт хавдрын нийт өвчлөлийн түвшинг хүйсээр харвал 2019 онд эрэгтэйчүүдийнх 19.9 болж, эмэгтэйчүүдээс 1.8-аар их, 2010 оныхоос 2.2-оор нэмэгдсэн байна.


Зураг 2. 4. Хорт хавдраар шинээр өвчлөгчдийн түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2010, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-II

Хорт хавдрын өвчлөлийг насны бүлгээр, 2019 оны байдлаар харвал хорт хавдраар өвчлөгчдийн 90 гаруй хувийг 40-өөс дээш насныхан эзэлж, өвчлөлийн түвшинг хүйсээр харвал 0-29 насны хооронд хүйсийн ялгаа бага бол 30-44 насанд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2.5-4.2-оор их, 45-аас дээш насанд эрэгтэйчүүд 2.9-71.6-гаар их байна. Энэ хандлага 2010 оныхтой адил байна.


Зураг 2. 5. Хорт хавдрын шинэ өвчлөлийн түвшин (10000 хүн амд), бүсээр, 2010, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-II

Хорт хавдрын шинэ өвчлөлийн (10000 хүнд ногдох) түвшинг бүсээр харвал 2010 онд баруун болон хангайн бүсэд улсын дундажтай адил, зүүн болон төвийн бүсэд улсын дунджаас 1-2-оор их байсан бол 2019 онд улсын дундаж 19 болж, 2010 оныхоос 2-оор нэмэгдсэн байна. 2019 онд бүх бүсэд улсын дунджаас 1-8-аар их болсон байна. 2010 онд төвийн бүсэд хамгийн их байсан бол 2019 онд зүүн бүсэд байна.

Зураг 2. 6. Хорт хавдрын шинэ өвчлөлийн түвшин (10000 хүн амд ногдохоор), аймаг, нийслэлээр, 2019 он




Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Хорт хавдраар шинээр өвчлөгчдийн түвшин 2019 оны байдлаар Говьсүмбэр, Баянхонгор, Улаанбаатар, Баян-Өлгий, Өмнөговь аймагт улсын дунджаас 2-7-гоор бага, Дорноговь аймагт адил, бусад аймагт улсын дунджаас 1-14-өөр их, хамгийн их нь зүүн бүсийн Хэнтий аймагт 33 байна.

Дэлхий эрүүл мэндийн байгууллагаас хүүхэд насанд тохиолдож буй хорт хавдрын насыг 0-19 насаар тооцдог. Монгол улсад 2010-2019 онд 0-19 насны 878 хүүхдэд хорт хавдар шинээр оношлогдсоны 469 (53.4%) эрэгтэй, 409 (46.5%) эмэгтэй хүүхэд байна. Хүүхэд насанд тохиолдож буй хорт хавдрын бүтцийг үзэхэд 70 хувийг булчирхай, тархи, цусны, нүд, холбох зөөлөн эд, тунгалагийн булчирхай, ясны хорт хавдрууд эзэлж байна. 2010-2019 онд 0-19 насны 367 хүүхэд хорт хавдрын шалтгааны улмаас нас барсан байна.

Зураг 2. 7. 0-19 насанд тохиолдож буй хорт хавдар, өвчний төрөл, 2010-2019 оны дундаж, хувиар



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Монгол Улсад 2019 оны байдлаар хорт хавдрын өвчтэй нийт 20913 хүн амьдарч байгаагийн 391 (1.8 %) нь 0-19 насны хүүхэд байна.

Улсын хэмжээнд 2010-2019 онд нийт 54607 хорт хавдрын шинэ тохиолдол оношлогдсоны 20200 тохиолдол буюу 37.0 хувийг элэгний хорт хавдар эзэлж байна.

Хорт хавдраар шинээр өвчлөгчдийн түвшинг тэргүүлэх 5 өвчний төрлөөр сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад элэг, умайн хүзүү, улаан хоолойн хавдрын өвчлөлийн түвшин 0.1-0.3-аар буурч, ходоод, уушгины хавдрын өвчлөлийн түвшин 0.1-0.4-өөр нэмэгдсэн байна. Харин өмнөх онтой харьцуулахад ходоодны хавдрын өвчлөл 0.3-аар нэмэгдэж, бусад өвчлөл 0.1-0.2-оор буурчээ.

Хорт хавдрын өвчлөлийн түвшинг төрлөөр, дүнд эзлэх хувиар, сүүлийн 10 жилийн байдлаар харвал элэгний хорт хавдар тэргүүлж байна. 2019 оны байдлаар хорт хавдрын төрлийг дүнд эзлэх хувиар сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад ходоод, уушгины хавдрын өвчлөл 0.3-2.1 пунктээр өсөж, бусад өвчлөл 0.6-2.0 пунктээр буурсан байна.

## Хүснэгт 2. 1. Хорт хавдраар шинээр өвчлөгчид, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2010-2019 он

Хорт хавдрын төрөл	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
<b>Нийт хорт хавдар</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Элэг	38.6	38.5	37.7	37.4	35.9	39.1	39.6	39.8	37.8	36.1
Ходоод	13.9	14.4	14.6	14.4	16.6	14.7	15.8	15.3	15.5	17.3
Уушги	8.0	8.1	7.4	7.9	7.8	7.2	7.7	7.5	8.9	8.1
Улаан хоолой	7.6	6.2	7.3	6.3	7.2	6.6	5.7	5.9	6.7	5.9
Умайн хүзүү	8.0	8.6	7.7	8.4	9.3	7.7	6.9	6.1	6.4	5.5
Бусад	23.9	24.2	25.3	25.6	23.2	24.8	24.4	25.4	24.7	27.0

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Харин өмнөх онтой харьцуулахад ходоодны хавдрын өвчлөл 1.8 пунктээр өсч, бусад өвчлөл 0.8-1.6 пунктээр буурчээ.

Хорт хавдраар шинээр өвчлөгчдийг сүүлийн 20 жилийн байдлаарх өсөлт, бууралтын хандлага, Үндэсний статистикийн хорооноос тооцсон хүн амын 2045 он хүртэлх хэтийн тооцоог ашиглан хорт хавдраар шинээр өвчлөгчдийн түвшинг зонхилон тохиолдох өвчний төрлөөр 2045 он хүртэлх таамаглалыг эксел программын trendline оруулж өнгөрсөн 20 жилийн хугацааны өсөлт, бууралттай хамгийн ойролцоо тэгшитгэлийн загварыг ашиглан тооцсон.

Хорт хавдрын нийт өвчлөлийн хувьд polynomial загварын  $y=3.7059x^2+92.005x+2926.7$ ;  $R^2=0.9588$

Элэгний хорт хавдар: polynomial  $y=1.2974x^2+38.241x+1089$ ;  $R^2=0.9296$


Ходоодны хорт хавдар: polynomial  $y=1.2154x^2+3.6299x+457.13$ ;  $R^2=0.9428$

Уушгины хорт хавдар: polynomial  $y=1.0958x^2-14.493x+365.93$ ;  $R^2=0.7355$

Умайн хүзүүний хорт хавдар: power  $y=166.67x^{0.3059}$ ;  $R^2=0.7715$

Улаан хоолойн хорт хавдар: polynomial  $y=0.2418x^2-0.1371x+283.69$ ;  $R^2=0.5794$  томъёог ашигласан.

Зураг 2. 8. Хорт хавдрын өвчлөлийн түвшин (10000 хүн амд ногдох), зонхилон тохиолдох өвчний төрлөөр, 2001-2045 он






Нийт хорт хавдрын өвчлөлийн түвшин 2001-2014 оны дунджаар 15.7 байсан бол сүүлийн 2015-2019 оны дунджаар 18.8 болж, 3.1-ээр өссөн бол 2041-2045 оны дунджаар 29.2 болж, 10.5-аар өсөхөөр байна. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин 2001 - 2014 оны дунджаар 5.9 байсан бол сүүлийн 5 жилийн дунджаар 7.2 болж, 1.3-аар өсч, 2041-2045 оны дунджаар 10.9 болж, 1.5 дахин өсөх таамаглал гарсан.

Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшин сүүлийн 5 жилийн дунджаар 3.0 болж, өмнөх 14 жилийн дунджаас 0.6-гаар өссөн бол 2041-2045 оны дунджаар 6.1 болж, 2 дахин өсөхөөр байна.

Зураг 2. 9. Хорт хавдрын өвчлөлийн түвшин (10000 хүн амд ногдох), зонхилон тохиолдох өвчлөлийн төрлөөр, 2001-2045 он



Уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшин сүүлийн 5 жилийн дунджаар 1.5 болж, өмнөх 14 жилийн дунджаас 0.2-оор нэмэгдсэн байна. 2041-2045 онд энэ үзүүлэлт 3.8 болж, сүүлийн 5 жилийн дунджаас 2.6 дахин нэмэгдэхээр байна.

Улаан хоолойн хавдрын өвчлөл сүүлийн 5 жилийн дунджаар 1.2 болж, өмнөх 14 жилийн дундажтай адил, 2041-2045 оны дунджаар 1.5 болж, нэмэгдэх хандлагатай байна. Харин умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшин сүүлийн 5 жилийн дунджаар 1.2 болж, өмнөх 14 жилийн дунджаас 0.1-ээр буурч, 2041-2045 онд 1.1 болж, буурах таамаглал гарсан байна.


### Элэгний хорт хавдрын өвчлөл

Монгол Улсын элэгний анхдагч хорт хавдар үүсэх гол шалтгаан нь гепатит В (HBV), С (HCV) эсвэл дельта (HDV) вирусийн архаг халдвар, түүнчлэн согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс үүдэлтэй гэдэг нь судалгаагаар тогтоогдсон<sup>6</sup>.

ДЭМБ-ын мэдээллээр дэлхийн дунджаар 100 000 хүн амд ногдох элэгний хорт хавдрын тохиолдлын тоо **8.4, түүнээс их** байхыг өвчлөл **маш өндөр** гэж тооцдог. Гэвч Монгол улсад энэ үзүүлэлт 2019 онд 68.4 болж, даруй 8.1 дахин их байна.

Монгол Улсын хэмжээнд элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин 2019 онд 6.8 болж, сүүлийн 10 жилийн дундаж, өмнөх оноос тус тус 0.1-ээр буурсан байна. Элэгний хорт хавдрын өвчлөлийг хүйсээр, дүнд эзлэх хувиар харвал 2019 онд нийт өвчлөгчдийн 54.9 хувийг эрэгтэйчүүд эзэлж, сүүлийн 10 жилийн дунджаас 1.7 пунктээр буурч, өмнөх оноос 1.1 пунктээр нэмэгдсэн байна. Харин эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2019 онд 45.1 болж, эрэгтэйчүүдээс 9.8 пунктээр бага, сүүлийн 10 жилийн дунджаас 1.7 пунктээр нэмэгдэж, өмнөх оноос 1.1 пунктээр буурчээ.


Зураг 2. 10. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2010-2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Монгол Улсын Засгийн газраас “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг 2017 оноос хойш хэрэгжүүлснээр сүүлийн 3 жилд элэгний хорт хавдрын өвчлөл буурах хандлагатай байна.


Зураг 2. 11. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин, насны бүлгээр, 2010, 2019 он



Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин 65-аас дээш насныханд хамгийн их бөгөөд 2019 онд 2010 онтой харьцуулахад 10-19 насанд илрээгүй, 25-29 насанд адил түвшинд, 0-4, 20-24 насанд 0.1-ээр нэмэгдэж бусад насны бүлэгт 0.1-8.7-гоор тус тус буурсан байна.

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-II

Зураг 2. 12. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин, (10000 хүн амд ногдох), хүйсээр, 2010, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшинг хүйсээр харвал 2019 онд эрэгтэйчүүдийнх 7.6 болж, эмэгтэйчүүдээс 1.5-аар их, 2010 оныхтой адил түвшинд байна.

Харин эмэгтэйчүүдийн өвчлөлийн түвшин 2019 онд 6.1 болж, 2010 оныхоос 0.6-гаар нэмэгдсэн байна. Элэгний хорт хавдраар өвчлөгчдийг насны бүлгээр харвал 95.5 хувь нь 45-аас дээш насныхан байгаа нь 2010 оноос 2.0 пунктээр нэмэгдсэн байна.

Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшинг бүсээр харвал 2010 онд баруун бүс улсын дунджаас 0.3-аар бага бусад бүсэд улсын дунджаас 0.3-1.4-өөр их байсан байна. Энэ үзүүлэлт 2019 онд бүх бүсэд улсын дунджаас 0.6- 6.4-өөр их болсон байна. 2019 онд зүүн бүсэд хамгийн их 13.2 болж, 2010 оныхоос 1.7 дахин их болсон байна.


Зураг 2. 13. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин (10000 хүн амд ногдох), бүсээр, 2010, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Хорт хавдраар шинээр өвчлөгчид дотор элэгний хорт хавдраар өвчлөгчдийг аймаг, нийслэлээр харвал Баянхонгор, Говьсүмбэр, Орхон, Улаанбаатар, Өмнөговь, Баян-Өлгийд улсын дунджаас 0.3-3.7-гоор бага бусад аймагт 0.1-10.4-өөр их байна. Элэгний өвчлөлийн түвшин Хэнтий аймагт хамгийн их, Баян-Өлгийд хамгийн бага байна.

Зураг 2. 14. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин, (10000 хүн амд ногдох), аймаг, нийслэлээр, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

### Ходоодны хорт хавдрын өвчлөл


Архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх, тамхи татах, жимс жимсгэнэ, хүнсний ногооны хэрэглээ бага байх, хелико бактерийн халдвар, удамшлын генийн өөрчлөлт зэрэг нь ходоодны хавдрын эрсдэлт хүчин зүйлс болдог.

Монголын ард түмний уламжлалт халуун цай, хоол хүнс, мах идэх нь ходоод, улаан хоолойн хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл болохыг Доржготов нарын судалгаанд дурдсан байдаг<sup>7</sup>.

Улсын хэмжээнд 2010-2019 оны хооронд ходоодны хорт хавдрын 8137 шинэ тохиолдол бүртгэгдсэн байна. 2019 онд ходоодны хорт хавдрын 1046 шинэ тохиолдол бүртгэгдэж, сүүлийн 10 жилийн дунджаас 232 (28.5%)-оор, өмнөх оноос 145 (16.1%)-аар тус тус нэмэгдсэн байна.

Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшин (10000 хүн амд ногдох) 2019 онд 3.3 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 0.5-аар, өмнөх оноос 0.4-өөр тус тус нэмэгдсэн байна.


Зураг 2. 15. Ходоодны хорт хавдрын өвчлөл, 2010-2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Ходоодны хорт хавдрын өвчлөлийг хүйсээр харвал 2019 оны байдлаар 68.5 хувийг эрэгтэйчүүд эзэлж 2010 оныхоос 7.0 пунктээр нэмэгдсэн байна.


Зураг 2. 16. Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшин, хүйсээр, насны бүлгээр, 2010, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшин 2019 оны байдлаар эрэгтэйчүүдийнх 4.6 болж, эмэгтэйчүүдээс 2.2 дахин, 2010 оныхоос 1.6-гаар их байна. Насны бүлгээр харвал 50-аас дээш насныхан 82.7 хувийг эзэлж, 2010 оныхоос 10.2 пунктээр нэмэгдсэн байна.


Зураг 2. 17. Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшин, бүсээр, 2010, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшинг газар зүйн бүс нутгаар харьцуулан үзэхэд 2010 онд төвийн бүсийн өвчлөлийн түвшин 1.2 болж, улсын дунджаас 1.1-ээр бага бусад бүсэд улсын дунджаас 0.2-0.7-гоор их байсан. Харин 2019 онд хангайн бүсэд улсын дундажтай адил бусад бүсэд улсын дунджаас 0.2-1.1-ээр их байна. Баруун бүсэд хамгийн их 4.4 болж, 2010 оныхоос 1.7 дахин өссөн байна.

Зураг 2. 18. Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшин, бүсээр, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшинг 2019 оны байдлаар, аймаг, нийслэлээр харвал Дорноговь, Улаанбаатар, Сүхбаатар, Булган, Өвөрхангай, Баян-Өлгий, Өмнөговь, Баянхонгорт улсын дунджаас 0.4-1.4-өөр бага, Дархан-Уул аймагт улсын дундажтай адил, бусад аймагт 0.1-4.6-гаар их байна. Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшин хамгийн өндөр нь Увс аймаг, хамгийн бага нь Баянхонгор аймаг байна.

### Уушгины хорт хавдар

Уушгины хорт хавдрыг үүсгэдэг гол хүчин зүйл нь хүн амын амьдралын дадал зуршил, хоол хүнс, хүрээлэн буй орчин зэрэг байдаг.

Манай улсын хувьд уушгины хорт хавдрын өвчлөл элэг, ходоодны хорт хавдрын өвчлөлийн дараа орж байна.

Монгол Улсын хэмжээнд 2010-2019 оны хооронд уушгины хорт хавдрын 4182 шинэ тохиолдол бүртгэгдсэн байна. 2019 онд энэ үзүүлэлт 492 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 74 (17.6%)-өөр нэмэгдэж, харин өмнөх оноос 25 (4.8%)-аар буурсан байна.


Зураг 2. 19. Уушгины хорт хавдрын өвчлөл, 2010-2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшин 2019 онд 1.5 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 0.1-ээр нэмэгдэж, өмнөх оноос 0.1-ээр буурсан байна.

Зураг 2. 20. Уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшин, насны бүлэг, хүйсээр, 2010-2019 он




Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Уушгины хорт хавдрын өвчлөлийг 2019 оны байдлаар, хүйсээр харвал 78.9 хувь нь эрэгтэйчүүд байгаа нь 2010 оныхоос 3.8 пунктээр буурч харин эмэгтэйчүүдийн өвчлөл энэ хэмжээгээр нэмэгдсэн байна.

Харин уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшин 2019 оны байдлаар харвал эрэгтэйчүүдийнх 2.5 болж, 2010 оныхоос 0.2-оор, эмэгтэйчүүдийн 0.6 болж, 0.1-ээр тус тус нэмэгдсэн байна. Энэ үзүүлэлтийг насны бүлгээр харвал 91.2 хувь нь 45-аас дээш насныхан байгаа нь 2010 оныхоос 3.3 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 2. 21. Уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшин, бүсээр, 2010, 2019 он




Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшин 2010 онд баруун бүсэд 1.1 болж, улсын дунджаас 0.3-аар бага, бусад бүсэд улсын дунджаас 0.1-0.5-аар их байсан байна. Харин 2019 онд энэ үзүүлэлт баруун бүсэд улсын дундажтай адил, бусад бүсэд улсын дунджаас 0.4-1.1-ээр их байна. Зүүн бүсэд өвчлөлийн түвшин хамгийн их 2.6 болж, 2010 оныхоос 1.6 дахин нэмэгдсэн байна.



Зураг 2. 22. Уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшин, аймаг, нийслэлээр, 2019 он



Энэ үзүүлэлтийг аймаг, нийслэлээр харвал Дорнод, Сэлэнгэ, Завхан, Архангай, Улаанбаатар, Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь, Баян-Өлгий, Говьсүмбэрт 0.1-0.9-өөр бага, Дорнод аймагт улсын дундажтай адил, бусад аймагт улсын дунджаас 0.1-2.3-аар их байна. Өвчлөлийн түвшин хамгийн өндөр нь зүүн бүсийн Сүхбаатар аймагт 3.8, хамгийн бага нь төвийн бүсийн Говьсүмбэр аймагт 0.6 байна.


### Улаан хоолойн хорт хавдар

Улаан хоолойн хорт хавдрын үүсгэгч гол хүчин зүйл нь бусад хавдрын адил хүмүүсийн хорт зуршил архи, тамхины хэрэглээ, улаан хоолойн архаг, суурь өвчин, удамших хандлага зэрэг нөлөөлдөг байна.

Улсын хэмжээнд 2010-2019 оны хооронд улаан хоолойн хорт хавдрын өвчлөлийн 3446 шинэ тохиолдол бүртгэгдсэн байна. 2019 онд 359 шинэ тохиолдол бүртгэгдэж, сүүлийн 10 жилийн дунджаас 14 (4.2%)-өөр нэмэгдэж, харин өмнөх оноос 31 (7.9%)-ээр буурчээ.

Улаан хоолойн хорт хавдрын өвчлөлийн түвшин 2019 онд 1.1 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 0.1-ээр тус тус буурсан байна.


Зураг 2. 23. Улаан хоолойн хорт хавдрын өвчлөл, 2010-2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Улаан хоолойн өвчлөлийн түвшинг 2019 оны байдлаар хүйсээр харвал эрэгтэйчүүдийнх 1.2 болж, эмэгтэйчүүдээс 0.2-оор их, 2010 оныхтой адил түвшинд байна. Харин эмэгтэйчүүдийн өвчлөлийн түвшин 2019 онд 1.0 болж, 2010 оныхоос 0.3-аар буурсан байна.


Зураг 2. 24. Улаан хоолойн хорт хавдрын өвчлөлийн түвшин, хүйс, насны бүлгээр, 2010, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Өвчлөлийн түвшин 65-аас дээш насныханд бусад насныхнаас их байгаа бөгөөд 2019 онд 65-аас дээш насны эрэгтэйчүүдийнх 20.6 болж, 2010 оныхоос 0.7-гоор, эмэгтэйчүүдийнх 15.4 болж, 4.2-оор тус тус буурсан байна.


Зураг 2. 25. Улаан хоолойн хорт хавдрын өвчлөлийн түвшин, бүсээр, 2010, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Улаан хоолойн хорт хавдрын өвчлөлийн түвшинг бүсээр харвал 2010 онд зүүн бүсэд улсын дунджаас 0.5-аар бага, бусад бүсэд улсын дунджаас 0.1-1.0-ээр их байсан байна. Харин 2019 онд төвийн болон зүүн бүсэд улсын дунджаас 0.1-0.2-оор бага, хангайн болон баруун бүсэд улсын дунджаас 0.4-1.1-ээр их байна. Баруун бүсэд өвчлөлийн түвшин 2.2 болж хамгийн их байгаа нь 2010 оныхоос 0.1-ээр буурсан байна.

Зураг 2. 26. Улаан хоолойн хорт хавдрын өвчлөлийн түвшин, аймаг, нийслэлээр, 2019 он




Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Улаан хоолойн өвчлөлийн түвшинг 2019 оны байдлаар, аймаг, нийслэлээр харвал Дорнод, Дархан-Уул, Булган, Улаанбаатар, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговьт улсын дунджаас 0.1-0.8-аар бага Дундговь аймагт улсын дундажтай адил, бусад аймагт улсын дунджаас 0.1-2.1-ээр их байна. Хамгийн их нь Увс, хамгийн бага нь Өмнөговь аймаг байна.

### Умайн хүзүүний хорт хавдар

Умайн хүзүүний хорт хавдар нь Монгол эмэгтэйчүүдийн хорт хавдрын шалтгааны хоёрдугаарт орж, эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Умайн хүзүүний хорт хавдрын гол шалтгаан нь хүний папиллома вирусийн (HPV) омгууд бүхий архаг халдвар бөгөөд энэ нь бэлгийн замын халдварт өвчнөөс голчлон үүсдэг байна<sup>8</sup>.

Зураг 2. 27. Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, 2010-2019 он




Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол 2019 онд 333 бүртгэгдэж сүүлийн 10 жилийн дунджаас 59 (15.1%) –өөр, өмнөх оноос 39 (10.5%)-өөр тус тус буурчээ.

Харин өвчлөлийн түвшин 2019 онд 1.0 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 0.4-өөр, өмнөх оноос 0.2-оор мөн буурсан байна.

Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшинг насны бүлгээр 2010, 2019 оныг харьцуулан харвал 2010 онд 15-19 насны эмэгтэйчүүд өвчилж байсан бол 2019 онд нас нь хойшилж 35-39 насныхнаас өвчлөл эхэлсэн байна. Насны бүлэг дэх өвчлөлийн түвшин 2019 онд 2010 оныхтой харьцуулахад буурсан байна. Тухайлбал, 2019 онд нийт өвчлөлийн түвшин 2.1 болж, 2010 оныхоос 0.5-аар буурчээ. 2019 онд 55-59 онд хамгийн их буюу 6.5 болж, 2010 оныхоос 2.6-гаар, 60-64 насныхан 6.3 болж 1.8-аар, 40-44 насныхан 5.5 болж 0.9-өөр тус тус буурсан байна.

Зураг 2. 28. Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшин, насны бүлгээр, 2010, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшинг бүс нутгаар харвал 2010 онд төвийн бүсэд хамгийн их буюу улсын дунджаас 0.3-аар их, бусад бүсэд улсын дунджаас 0.1-0.5-аар бага байна. Харин 2019 онд 2010 оныхтой харьцуулахад хангайн бүс 1-ээр, төвийн бүсийнх 0.1-ээр нэмэгдэж, бусад бүсийн хувьд 0.1-0.3-аар буурсан байна. Өвчлөлийн түвшин хамгийн өндөр нь төвийн бүс байна.

Зураг 2. 29. Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшин, бүсээр, 2010, 2019 он




Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшинг 2019 оны байдлаар аймаг, нийслэлээр, улсын дундажтай харьцуулбал Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Дундговь, Дорнод, Говьсүмбэр, Дорноговь, Баянхонгор, Завхан, Архангай аймагт 0.1-1.9-өөр их

Ховд, Булган, Хөвсгөл, Орхон аймагт адил түвшинд, бусад аймаг, нийслэлд 0.1-0.7-гоор бага байна. Хамгийн их нь Дархан-Уул, хамгийн бага нь Баян-Өлгий аймагт байна.


Зураг 2. 30. Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшин, аймаг, нийслэлээр, 2019 он




Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

### БҮЛЭГ 3. ХАВДРЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Хорт хавдрын шинэ өвчлөлийн оношлогдсон үе шатыг сүүлийн 10 жилийн дунджаар харвал **10** хүний **2** нь эрт үедээ, **8** нь хожуу үедээ оношлуулж байна.



### Хорт хавдрын хяналт, өвчний төрөл, хүйс, эмчилгээ, хувиар 2019 он




Хорт хавдрын хяналтад байгаа **10** хүн тутмын **6** нь эмэгтэй, **4** нь эрэгтэй

Хорт хавдартай нийт хүний **53.5** хувь нь хөнгөвчлөх, **22.6** хувь нь мэс заслын, **23.9** хувь нь бусад төрлийн эмчилгээ хийлгэж байна.

Хорт хавдрын хяналтанд орсон, 5-аас дээш жил амьдарч байгаа хүмүүсийн хувь, зонхилох өвчний төрлөөр, 2019 он



Элэгний хорт хавдрын **21.0** хувь



Уушгины хорт хавдрын **23.0** хувь



Улаан хоолойн хорт хавдрын **25.0** хувь



Ходоодны хорт хавдрын **32.0** хувь




Умайн хүзүүний хорт хавдрын **51.8** хувь

## Хавдрын эрт илрүүлэг, үзлэг

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 78 дугаар тушаалаар “Хорт хавдрын эрт илрүүлгийн бүртгэл, мэдээллийн удирдамж”, “Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг, эргэн дуудах тогтолцоо” бүртгэл мэдээллийн удирдамж гарснаар эрт илрүүлэг, үзлэг хийгдэж эхэлсэн.

Улсын хэмжээнд 2019 оны байдлаар умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 88493 эмэгтэй хамрагдаж, энэ нь хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн 53.9 хувийг эзэлж байна.

Зураг 3. 1. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь, 2012-2019 он



Эх үүсвэр: Хавдар судлалын үндэсний төвийн захиргааны мэдээлэл

Улсын хэмжээнд умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн зорилтот насны эмэгтэйчүүдийн хамрагдалтын хувь 2017-2018 онуудад 37.4 хувьтай байсан бол 2019 онд 53.9 хувь болж нэмэгдсэн боловч нийслэл Улаанбаатар хотод улсын болон аймгийн дундаж дүнгээс байнга бага байгаа нь анхаарал татаж байна.

Хүснэгт 3. 1. Эрт илрүүлэг үзлэгээр илэрсэн умайн хүзүүний хорт хавдрын үе шат, 2012-2019 он

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Шинээр оношлогдсон тохиолдлын тоо	39	118	103	78	68	55	35	31
I үе	13.2	16.3	41.2	52.5	58.8	47.3	51.4	48.4
II үе	16.4	13.3	10.3	23.0	16.2	18.2	28.6	19.4
Эрт үе шатанд илэрсэн хувь	29.6	29.6	51.5	75.5	75.0	65.5	80.0	67.7

Эх үүсвэр: Хавдар судлалын үндэсний төвийн захиргааны мэдээлэл




Хүснэгт 3. 2. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт, аймаг нийслэлээр, 2019 он

Аймаг, нийслэл, бүс	Умайн хүзүүний хорт хавдар		
	Хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн тоо	Хамрагдсан зорилтот насны эмэгтэйчүүдийн тоо	Зорилтот насны эмэгтэйчүүдийн хамрагдалтын хувь
<b>Улсын дүн</b>	<b>229 464</b>	<b>88 493</b>	<b>38.6</b>
<b>Баруун бүс</b>	<b>25 726</b>	<b>12 956</b>	<b>50.4</b>
Баян-Өлгий	6 170	2 547	41.3
Говь-Алтай	3 934	2 081	52.9
Завхан	4 938	2 355	47.7
Увс	5 167	2 962	57.3
Ховд	5 517	3 011	54.6
<b>Хангайн бүс</b>	<b>41 698</b>	<b>22 491</b>	<b>53.9</b>
Архангай	6 352	3 147	49.5
Баянхонгор	5 947	3 752	63.1
Булган	4 241	2 665	62.8
Орхон	7 910	2 315	29.3
Өвөрхангай	7 966	4 809	60.4
Хөвсгөл	9 282	5 803	62.5
<b>Төвийн бүс</b>	<b>34 947</b>	<b>18 423</b>	<b>52.7</b>
Говьсүмбэр	1 126	545	48.4
Дархан-Уул	7 384	4 685	63.4
Дорноговь	4 818	2 755	57.2
Дундговь	3 125	2 008	64.3
Өмнөговь	4 713	1 836	39.0
Сэлэнгэ	7 541	3 028	40.2
Төв	6 240	3 566	57.1
<b>Зүүн бүс</b>	<b>15 106</b>	<b>9 410</b>	<b>62.3</b>
Дорнод	5 581	2 935	52.6
Сүхбаатар	4 325	3 370	77.9
Хэнтий	5 200	3 105	59.7
<b>Улаанбаатар</b>	<b>111 987</b>	<b>25 213</b>	<b>22.5</b>

Эх үүсвэр: Хавдар судлалын үндэсний төвийн захиргааны мэдээлэл

Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын бүс нутгаар харвал 2019 онд бүх бүсэд улсын дунджаас 11.8-23.7 пунктээр их, Улаанбаатарт улсын дунджаас 16.1 пунктээр бага байна. Энэ үзүүлэлт аймаг бүрд харилцан адилгүй бөгөөд 2019 онд хамгийн өндөр хамрагдалттай Сүхбаатар аймаг бол, хамгийн бага нь Орхон аймаг байна.

Зураг 3. 2. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь, зорилтот насны ангиллаар, 2019 он




Эх үүсвэр: Хавдар судлалын үндэсний төвийн захиргааны мэдээлэл

Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хамралтын хувийг улсын дүнгээр авч үзэхэд 36, 39 болон 42 насанд өндөр байгаа бөгөөд 54 болон 57 насанд хамралт бага хувийг эзэлж байна. Хамгийн их болон бага хамралтын хувийн зөрүү нь 9.1 байна. Дүүргийн дундаж үзүүлэлт насны ангиллаар харьцуулахад 24.4-39.2 хувиар аймгийн дундаж үзүүлэлтээс бага байна. Нас ахих тусам хорт хавдраар өвчлөх эрсдэл нэмэгддэг атал умайн хүзүүний хорт хавдрын илрүүлэг үзлэгт 50-аас дээш насны эмэгтэйчүүдийн хамрагдалт бусад насны ангилалтай харьцуулахад бага байгааг анхаарвал зохино.

Улсын хэмжээнд 2019 онд умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгийн эсийн шинжилгээний 94336 сорьц шинжилгээнд хамрагдсанаас шаардлага хангаагүй 3.1%, хэвийн 92,6%, өөрчлөлт эерэг гарсан 4,3 хувийг тус тус эзэлж байгаа ба хариу гараагүй хүлээгдэж буй 19054 шинжилгээ байна.

Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан нийт эмэгтэйчүүдээс үтрээний дурангийн шинжилгээнд 616, умайн хүзүүний эмгэгийг түлэх эмчилгээнд 95, хавдрын урьдал эмгэгийг эмчлэх эмчилгээг 6471 эмэгтэй хийлгэж, умайн хүзүүний хорт хавдрын 42 тохиолдол шинээр бүртгэгдсэн байгаа ба үүнээс 67.7 хувь нь эрт үедээ оношлогдсон байна.

Зураг 3. 3. Үтрээн дурангийн шинжилгээний үзүүлэлт, 2012-2019



Эх үүсвэр: Хавдар судлалын үндэсний төвийн захиргааны мэдээлэл

Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн удирдамжид шинжилгээний хариу эерэг гарсан эмэгтэйчүүдийг үтрээн дурангийн шинжилгээнд хамруулна гэж заасан боловч энэ үзүүлэлт хангалтгүй байсаар байна. 2019 онд 11 аймаг, 6 дүүрэгт үтрээн дурангийн шинжилгээ огт хийгдээгүй байна.

## Хүснэгт 3. 3. Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэг, бодит тоогоор, 2013-2019

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Хөхний өмөнгийн боломжит илрүүлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо	92 123	179 233	226 304	286 921	354 572	388 528	411 989
Маммографи шинжилгээнд хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо	623	396	285	169	130	187	272
Илрүүлэг үзлэгээр илэрсэн хорт хавдрын шинэ тохиолдлын тоо	24	23	20	15	13	18	9


Эх үүсвэр: Хавдар судлалын үндэсний төвийн захиргааны мэдээлэл

2019 онд хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт улсын дүнгээр 411989 эмэгтэй, үүнээс 272 эмэгтэй маммографи шинжилгээнд хамрагдсан байна. Хөхний хорт хавдрын өндөр эрсдэлт бүлгийн 162 эмэгтэй бүртгэгдсэн, 129 эмэгтэй хавдрын урьдал эмгэгийн эмчилгээнд хамрагдаж, 23 мэс ажилбар хийгдсэн. Хөхний хорт хавдрын 9 шинэ тохиолдол илрүүлэг үзлэгээр илэрсэн байна.

### Хавдрын хяналт, тусламж үйлчилгээ

Хорт хавдрын эмчилгээний үр дүн хорт хавдар оношлогдох үеийн үе шатаас ихээхэн шалтгаалдаг. Хорт хавдрын шинэ өвчлөлийн оношлогдсон үе шатыг сүүлийн 10 жилийн дунджаар харвал 10 хүний 2 нь эрт үедээ, 8 нь хожуу үедээ хорт хавдрыг оношлуулж байна.


Зураг 3. 4. Хорт хавдрын өвчлөлийн оношлогдох үеийн үе шат, дүнд эзлэх хувиар, 2010- 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Энэ үзүүлэлт 2019 онд 27.5 хувь нь эрт үедээ оношлогдож, сүүлийн 10 жилийн дунджаас 4.7 пунктээр, өмнөх оноос 3.6 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

Зураг 3. 5. Хорт хавдрын оношлогдох үеийн үе шат, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2010, 2019 он




Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Хорт хавдрын оношлогдох үеийн үе шатыг дүнд эзлэх хувиар, өвчний төрлөөр, 2010 онтой харьцуулан харвал 2019 онд умайн хүзүүний хорт хавдрын 55.3 хувь нь эрт үедээ оношлогдож 12.8 пунктээр, ходоодны хорт хавдрынх 23.5 хувь болж, 1.4 пунктээр, элэгний хорт хавдрынх 22.5 хувь болж, 6.6 пункт, улаан хоолойн хорт хавдрынх 22.3 болж, 7.3 пункт, уушгиных 14.0 болж, 3.4 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

Монгол Улсын Засгийн газраас “Халдварт бус өвчинтэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийн 2017-2021 оны хооронд хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд тус хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд элэгний хорт хавдрын эр үеийн илрүүлгийн хувийг 2019 онд 20.7 болгох зорилт тавьсан нь 2019 онд биелсэн байна. Харин умайн хүзүүний хорт хавдрыг I дүгээр шатанд илрүүлэх хувийг 2019 онд 42.5 болгох зорилт 2019 онд 15.2 болж биелээгүй байна.

Зураг 3. 6. Хорт хавдрын хяналт, зонхилон тохиолдох төрөл, хүйс, дүнд эзлэх хувиар, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Монгол Улсад 2019 оны жилийн эцэст 19.9 мянган хүн хорт хавдрын улмаас аймаг дүүргийн хавдар судлаач их эмчийн хяналтад байгаагийн 7.0 (35.5%) мянга нь эрэгтэй, 12.9 (64.5%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Хорт хавдрын хяналтад байгаа хүмүүсийг өвчний төрлөөр, дүнд эзлэх хувиар, хүйсээр харвал уушги, ходоодны хорт хавдрын хяналтад байгаа эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 28.2-44.6 пунктээр их бусад өвчлөлийн эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна.

Хорт хавдрын өвчлөлийн түвшин эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдээс илүү байсан боловч хяналтад хамрагдалт эрэгтэйчүүдийн хувьд бага байна.

Хорт хавдрын хяналтад байгаа нийт хүмүүсийн 37.5 хувь нь 5, түүнээс дээш жил амьдарсан байна.

Зураг 3. 7. Хорт хавдрын хяналтад орсон, 5-аас дээш жил амьдарч байгаа хүмүүсийн хувь, зонхилох өвчний төрлөөр, 2019 он



Зонхилон тохиолдох хорт хавдрын хяналтад байгаа хүмүүсийн 5, түүнээс дээш жил амьдарсан хувь умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл хамгийн их 51.8, хамгийн бага нь элэгний хорт хавдрынх 21.0 байна.

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Хорт хавдрын хяналтад хамрагдалтын хувь 2019 онд эрэгтэйчүүдийнх 35.5 хувь болж, 2010 оныхоос 2.1 пунктээр буурчээ. Хяналтад хамрагдалтын хувь 2019 онд бүх бүсэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 15.2-33.7 пунктээр их байна.

Хяналтад хамрагдсан хүмүүсээс 5, түүнээс дээш жил амьдарч буй хувь 2019 онд 37.5 болж, 2010 оныхоос 17.0 пунктээр нэмэгдсэн байна. Энэ үзүүлэлт 2019 онд бүх бүсэд улсын дунджаас 0.2-6.1 пунктээр бага байна.

Хорт хавдрын хяналтад хамрагдалтын хувийг аймаг нийслэлээр харвал 2019 онд Дорнод, Төв, Улаанбаатар, Өмнөговьт улсын дунджаас 0.3-8.0 пунктээр бага, бусад аймагт 0.2-9.9 пунктээр их байна.


## Хүснэгт 3. 4. Хорт хавдрын хяналтын зарим үзүүлэлт, бүс, аймаг, нийслэлээр, 2010, 2019 он

Аймаг, нийслэл	Хорт хавдрын хяналтад хамрагдалтын хувь				Хяналтад хамрагдсан хүмүүсээс 5, түүнээс дээш жил амьдарсан хувь	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	2010	2019
	2010		2019			
<b>Улсын дүн</b>	37.6	62.4	35.5	64.5	20.5	37.5
<b>Баруун бүс</b>	45.8	54.2	42.4	57.6	17.0	31.4
Баян-Өлгий	47.1	52.9	47.5	52.5	14.4	27.6
Говь-Алтай	37.6	62.4	36.5	63.5	12.7	30.3
Завхан	41.3	58.8	39.9	60.1	19.2	29.8
Увс	58.5	41.5	47.5	52.5	3.2	37.1
Ховд	44.2	55.8	42.2	57.8	33.5	31.7
<b>Хангайн бүс</b>	38.5	61.5	39.6	60.4	15.2	34.0
Архангай	45.1	54.9	42.8	57.2	0.0	37.3
Баянхонгор	33.0	67.0	32.4	67.6	25.6	33.9
Булган	35.3	64.7	39.5	60.5	0.0	34.9
Орхон	38.6	61.4	39.7	60.3	34.7	31.8
Өвөрхангай	39.5	60.5	38.7	61.3	25.9	31.1
Хөвсгөл	38.7	61.3	41.5	58.5	3.7	35.5
<b>Төвийн бүс</b>	34.1	65.9	33.1	66.9	23.5	37.3
Говь-Сүмбэр	28.2	71.8	34.0	66.0	7.7	45.5
Дархан-Уул	32.5	67.5	26.2	73.8	24.4	37.0
Дорноговь	36.1	63.9	33.0	67.0	49.4	34.0
Дундговь	42.0	58.0	37.6	62.4	29.6	36.9
Өмнөговь	27.9	72.1	32.4	67.6	22.1	34.3
Сэлэнгэ	33.9	66.1	35.9	64.1	4.0	35.1
Төв	36.1	63.9	35.3	64.7	30.6	38.3
<b>Зүүн бүс</b>	39.9	60.1	37.6	62.4	23.3	32.1
Дорнод	33.0	67.0	36.5	63.5	37.3	30.0
Сүхбаатар	44.9	55.1	41.5	58.5	20.9	28.2
Хэнтий	44.1	55.9	36.0	64.0	9.4	37.8
<b>Улаанбаатар</b>	36.0	64.0	32.5	67.5	21.7	41.7

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Улсын хэмжээнд хавдрын орны тоог (100000 хүнд ногдох) сүүлийн 10 жилийн байдлаар харвал 2019 онд 5 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 1-ээр буурч, өмнөх онтой адил түвшинд байна. Хөнгөвчлөх эмчилгээний ор 2019 онд 6 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 1-ээр, өмнөх оноос 4-өөр тус тус буурсан байна.


Зураг 3. 8. Хавдрын ор (100000 хүнд ногдох), 2010-2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн боть-I

Хавдар өвчний улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн түвшин 2019 онд 32 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 6-гаар, өмнөх оноос 4-өөр тус тус нэмэгдсэн байна. Хөнгөвчлөх эмчилгээгээр эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн түвшин 2019 онд 17 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 7-гоор, өмнөх оноос 2-оор мөн л нэмэгджээ.

Зураг 3. 9. Хавдар өвчнөөр эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн түвшин (10000 хүнд ногдох), 2010-2019 он



Улсын хэмжээнд хорт хавдраар шинээр өвчлөгчдийн эмчилгээний төрлийг харвал нийт хорт хавдрын өвчлөлийн 53.5 хувь нь хөнгөвчлөх эмчилгээ, тусламж авсан нь умайн хүзүүнээс бусад өвчний төрөл бүрд адил байна. Энэ нь манай улсын хүн амын 70 гаруй хувь нь хорт хавдрын хожуу үедээ оношлогдон эмчилгээ хийх боломжгүй болсонтой холбоотой байна.

Хүснэгт 3. 5. Хорт хавдрын эмчилгээний төрөл, өвчний төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2019 он






Эмчилгээний төрөл	Элэг	Ходоод	Улаан хоолой	Уушиг	Умайн хүзүү	Нийт хорт хавдар
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Мэс засал	16.3	24.1	17.0	7.5	40.2	22.6
Туяа	-	0.1	7.2	1.0	12.0	1.5
Хими	3.8	4.4	3.6	10.6	3.6	6.3
Мэс засал + Туяа	-	0.4	0.8	-	2.7	0.6
Мэс засал + Хими	0.9	9.8	0.8	1.6	2.1	4.8
Хими + Туяа	0.3	0.3	3.1	2.0	18.3	1.9
Туяа + Хими + Мэс засал	-	0.3	2.2	0.8	2.7	1.0
Хими + Даавар эмчилгээ	0.5	0.7	0.6	-	-	0.5
Хөнгөвчлөх мэс засал	3.9	1.9	1.7	-	-	1.9
Бусад хөнгөвчлөх эмчилгээ, тусламж	67.6	53.6	56.0	73.0	13.8	53.5
Дархлаа дэмжих эмчилгээ	0.6	0.4	1.1	0.8	0.6	0.8
Даавар эмчилгээ	-	-	-	0.4	0.3	0.1
Эмчилгээнээс татгалзсан	6.0	4.1	5.8	2.2	3.6	4.6

Нийт хорт хавдраар шинээр өвчлөгчдийн эмчилгээний дараагийн их хувь эзэлж буй төрөл нь мэс заслын эмчилгээ бөгөөд умайн хүзүүний хорт хавдрын ихэнх буюу 40.2 хувь нь мэс заслын эмчилгээ хийгдсэн байна.




## БҮЛЭГ 4. ХАВДРЫН УРЬДАЛ ӨВЧНҮҮД

Хорт хавдрын зонхилон тохиолдож буй урьдал өвчнүүд

Өвчний нэр	2015 10000 хүнд ногдох	2019	Өөрчлөлт
Элэгний архаг хепатит 	182.7	227.9	45.2 ↑
Ходоодны үрэвсэлт өвчин 	161.3	219.5	58.3 ↑
Уушгины архаг бөглөрөл 	91.7	161.9	70.2 ↑
Улаан хоолойн сөөргөө 	11.1	16.5	5.4 ↑
Умайн хүзүүний шархлаа 	12.2	4.7	-7.5 ↓


Зонхилон тохиолдох хавдрын урьдал өвчний түвшин 2019 онд 2015 онтой харьцуулахад умайн хүзүүний шархлаа өвчний түвшин **7.5**-аар буурч, бусад өвчнийх **5.4-70.2**-оор өссөн байна.

Уушгины архаг бөглөрөл өвчний 10000 хүнд ногдох түвшин, хүйс, насны бүлэг, байршил, 2019 он



Өвчлөлийн түвшин 2019 онд 2015 онтой харьцуулахад 15-19 насанд **8.5** дахин өсчээ. **10** хүн тутмын **6** нь эмэгтэй, **4** нь эрэгтэй байна. Төвийн бүсэд улсын дунджаас **21.5**-аар их байна.

Ходоодны үрэвсэлт өвчний 10000 хүнд ногдох түвшин, хүйс, насны бүлэг, байршил, 2019 он




Өвчлөлийн түвшин 2019 онд 2015 онтой харьцуулахад 0-14 насанд хамгийн их буюу дунджаар **2.4** дахин өсчээ. **10** хүн тутмын **7** нь эмэгтэй, **3** нь эрэгтэй. Хангайн болон баруун бүсэд улсын дунджаас **4.0-8.3**-аар их байна.

Энэ бүлэгт хавдар өвчний урьдал өвчнүүдийн талаар судалсан. Хавдрын урьдал өвчнүүдэд олон өвчин ордог бөгөөд зөвхөн хавдрын тэргүүлэх 5 шалтгааны урьдал өвчнүүдийг дурдвал: бүх төрлийн хоргүй хавдар, вируст гепатит, вирусийн шалтгаант элэгний архаг үрэвсэл, элэгний хатуурал, ходоодны шархлаа, ходоод, нарийн гэдэсний шархлаат өвчин, уушгины архаг бөглөрөлт өвчин, уушгины хатуурал, шохойжилт, улаан хоолойн шархлаа өвчин, эндометриоз, умайн хүзүүний шархлаа ба шамраас, умайн хүзүүний дисплази, умайн хүзүүнээс бусад хэсгийн умайн үрэвсэлт өвчин, ходоодны ур, бүдүүн гэдэсний ур зэрэг өвчнүүд багтаж байна. Дээрх амбулаториор бүртгэгдсэн хавдрын зарим урьдал өвчнийг, давхардсан тоогоор, байршлаар, насны бүлэг, хүйсээр, сүүлийн 5 жилийн байдлаар харьцуулан дүн шинжилгээ хийв.

### Хоргүй хавдар /D10-D36/

Улсын хэмжээнд хоргүй хавдар өвчний түвшин 2019 онд 73 болж, 2015 оныхоос 1.5 дахин нэмэгджээ. Энэ үзүүлэлт 2015 онд Улаанбаатарт улсын дунджаас 9-өөр их бусад бүсэд улсын дунджаас 4-13-аар бага байжээ. Энэ үзүүлэлт 2019 онд 2015 онтой харьцуулахад Улаанбаатарт 85 болж, 28-аар, бүсүүдэд 21-25-аар тус тус нэмэгджээ. Хоргүй хавдар өвчний түвшин 2019 оны байдлаар Улаанбаатарт улсын дунджаас 12-оор илүү, бүсүүдэд 10-15-аар бага байна.


Зураг 4. 1. Хоргүй хавдар өвчин, 10000 хүнд ногдох, бүсээр, 2015, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.


2019 онд Говь-Алтай, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Улаанбаатарт улсын дунджаас 4-19-өөр илүү, бусад аймагт 7-28-аар бага байна. Энэ үзүүлэлт 2019 онд 2015 онтой харьцуулахад Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Ховд, Архангай, Орхон, Хөвсгөл, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Сүхбаатар, Хэнтийд 2 дахин, бусад аймагт 1 дахин нэмэгдсэн байна.

Зураг 4. 2. Хоргүй хавдар өвчин, 10000 хүнд ногдохоор, аймгаар, 2015, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.


Зураг 4. 3. Хоргүй хавдрын өвчлөлийн түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он



Хоргүй хавдрын өвчлөлийн түвшинг насны бүлгээр харвал 2019 онд 2015 онтой харьцуулахад бүх насны бүлэгт 1.3-3.3 дахин үүнээс 0-9 насанд хамгийн их буюу дунджаар 2.7 дахин нэмэгдсэн байна. Хоргүй хавдрын өвчлөлийн түвшин 40-өөс дээш насныханд хамгийн их бөгөөд 2015 онд дунджаар 110.5 болж, бусад насныхнаас 4.2 дахин их байсан бол 2019 онд 151.8 болж, 2015 оныхоос 41.3-аар нэмэгдэж, бусад насныхаас 3.6 дахин их болжээ.

Өвчлөлийн түвшинг хүйсээр харвал 2019 онд эмэгтэйчүүдийнх 110.0 болж, эрэгтэйчүүдээс 3.0 дахин их, 2015 оныхоос 1.5 дахин, эрэгтэйчүүдийнх 36.2 болж, 1.6 дахин тус тус нэмэгджээ.

Зураг 4. 4. Хоргүй хавдрын түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Өвчлөлийн түвшин бүх насны бүлэгт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.1-6.2 дахин их байна.

### Элэгний хорт хавдрын урьдал өвчнүүд

Элэгний хавдрын урьдал өвчинд архаг гепатит, элэгний хатуурал, элэгний хордлогот өвчин, архины шалтгаант элэгний өвчин, элэгний бусад өвчнийг оруулсан.

Хүснэгт 4. 1. Элэгний зарим өвчлөл, байршил, дүнд эзлэх хувиар, 2010, 2019 он

Тэргүүлэх өвчлөлүүд	Аймгийн дүн		Улаанбаатар		Улс	
	2015	2019	2015	2019	2015	2019
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Архаг гепатит	38.3	45.3	41.8	40.5	40.1	43.0
Элэгний хатуурал	34.8	28.9	35.3	36.5	35.1	32.4
Элэгний хордлогот өвчин	4.3	1.4	4.4	1.1	4.3	1.2
Архины шалтгаант элэгний өвчин	0.8	0.4	1.5	0.8	1.1	0.6
Элэгний бусад өвчин	21.8	24.0	17.0	21.1	19.3	22.7

Улсын хэмжээнд элэгний архаг гепатит өвчин элэгний нийт өвчлөлд хамгийн их хувийг эзэлж 2015 онд 38.3 хувь байсан бол, 2019 онд 45.3 болж 10.3 пунктээр нэмэгдэж бусад өвчлөлийн дүнд эзлэх хувь 0.4-4.0 пунктээр буурсан байна.

### Архаг гепатит өвчин

Элэгний архаг үрэвсэлт өвчин 2019 онд хангайн болон зүүн бүсэд улсын дундаж /94/-аас 9-13-аар илүү, баруун болон төвийн бүсэд 3-7-гоор бага байна. 2019 оны байдлаар 2015 онтой харьцуулахад хангайн бүсэд 49-өөр, баруун бүсэд 40-өөр, улсын хэмжээнд 27-гоор тус тус нэмэгдсэн байна.


Зураг 4. 5. Архаг гепатит өвчин, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

2019 онд Өвөрхангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Орхон, Дундговь, Дорноговь, Өмнөговь, Хөвсгөл, Сүхбаатар, Хэнтий, Төвд улсын дунджаас 2-69-өөр илүү, бусад аймагт 3-65-аар бага байна. 2015 оноос Баян-Өлгий, Говь-Алтайд 3 дахин, Ховд, Архангай, Баянхонгор, Орхон, Хөвсгөл, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Сэлэнгэ, Төв, Хэнтийд тус тус 2 дахин нэмэгдсэн байна.


Зураг 4. 6. Архаг гепатит өвчин, 10000 хүн амд ногдохоор, аймгаар, 2015, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Хүйсийн хувьд 2015 онд эрэгтэй 44.2 хувь, эмэгтэй 55.8 хувь, 2019 онд эрэгтэй 43.3 хувь, эмэгтэй 56.7 хувь байна.

Зураг 4. 7. Архаг хепатит өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он




Архаг хепатит өвчний түвшинг насны бүлгээр харвал 2019 онд 2015 онтой харьцуулахад бүх насанд 1.1-4.3 дахин нэмэгдэж үүнээс 0-9 насанд дунджаар хамгийн их буюу 3.2 дахин нэмэгдсэн байна.

Өвчлөлийн түвшин 35-39 насанд хамгийн их бөгөөд 2019 онд дунджаар 227.9 болж, бусад насныхны дунджаас 7.8 дахин, 2015 оныхоос 1.3 дахин их байна.

Архаг хепатит өвчний түвшинг хүйсээр харвал 2019 онд эмэгтэйчүүдийнх 104.7 болж, эрэгтэйчүүдээс 22.5-аар их, 2015 оныхоос 30.4-өөр нэмэгдсэн байна. Эрэгтэйчүүдийнх 82.2 болж, 2015 оныхоос 21.7-гоор нэмэгдсэн байна. Эрэгтэйчүүдийн өвчлөлийн түвшин эмэгтэйчүүдтэй харьцуулахад 0-19 насны хүүхэд дунджаар 0.8-аар, 30-44 насанд 15.4-өөр их, бусад насны бүлэгт 6.0-154.5-аар бага байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн зөрүү 60-64 насанд хамгийн их байна.

Зураг 4. 8. Архаг хепатит өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019 он




Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

## Элэгний хатуурал өвчин

Элэгний хатуурал өвчний (10000 хүн амд ногдох) түвшин 2019 онд улсын дунджаар 71 болж, зүүн бүсэд улсын дунджаас 4-өөр илүү, бусад бүсэд 2-19-өөр бага байна. Элэгний хатуурал өвчний (10000 хүн амд ногдох) түвшин 2019 онд 2015 онтой харьцуулахад улсын хэмжээнд 12-оор, бүх бүсэд 2-21-ээр тус тус нэмэгдсэн байна.


Зураг 4. 9 Элэгний хатуурал өвчин, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

2019 онд Ховд, Сэлэнгэ, Орхон, Сүхбаатар, Хэнтий, Улаанбаатар, Дархан-Уул, Төв Говь-Алтайд улсын дунджаас 0.1-49.2-оор их, бусад аймагт 1.7-51.2-оор бага байна.


Зураг 4. 10. Элэгний хатуурал өвчин, 10000 хүн амд ногдохоор, аймаг, нийслэлээр, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.



Зураг 4. 11. Элэгний хатуурал өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он




Элэгний хатуурал өвчний түвшинг насны бүлгээр харвал 2019 онд 30-аас дээш насанд дунджаар 178.4 болж, өмнөх насны бүлгийн дундажтай харьцуулахад 50 дахин их байна.

Энэ үзүүлэлтийг 2019 онд насны бүлгээр, 2015 онтой харьцуулахад 25-29 насанд 2.9-өөр, 60-аас дээш насанд 41.2-47.5-аар буурч бусад насанд 0.4-43.0-аар нэмэгджээ.

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Элэгний хатуурал өвчний түвшинг хүйсээр, насны бүлгээр харвал улсын хэмжээнд 2015 онд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 21.2-оор, 0-14, 50-аас дээш насанд 0.4-197.3-аар их, бусад насанд эрэгтэйчүүд их байжээ. Харин 2019 онд улсын хэмжээнд нийт эмэгтэйчүүдийн өвчлөлийн түвшин эрэгтэйчүүдээс 16.9-өөр, 0-19, 50-аас дээш насанд 0.8-163.5-аар их, бусад насанд эрэгтэйчүүд их байна.


Зураг 4. 12. Элэгний хатуурал өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019 он



### Элэгний хордлогот өвчин

Элэгний хордлогот өвчний түвшин 2019 онд 2015 онтой харьцуулахад 2.7 болж, 2.7 дахин, бүх бүсэд 0.6-7.4-өөр буурчээ. 2015 онд хангайн болон баруун бүсэд улсын дунджаас 2.3-4.4-өөр бага, нөгөө 2 бүсэд 2.2-3.2-оор их байсан бол 2019 онд энэ хандлага адил баруун болон хангайн бүсэд улсын дунджаас 0.6-гаар бага, нөгөө 2 бүсэд 0.4-2.0-оор их байна.


Зураг 4. 13. Элэгний хордлогот өвчин, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015 он, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.


Энэ үзүүлэлт Улаанбаатар хотод 2019 онд 2.3 болж, 2015 оноос 5.9-өөр буурчээ. 2019 онд Архангай, Өмнөговь, Дундговь, Баян-Өлгий, Дорноговь, Төв, Дархан-уул, Хэнтий, Сэлэнгэд улсын дундаж /2.7/-аас 0.1-5.3-аар илүү, бусад аймагт 0.2-1.8-аар бага, Ховд аймагт улсын дундажтай адил байна.

Зураг 4. 14. Элэгний хордлогот өвчин, 10000 хүн амд ногдохоор, аймаг, нийслэлээр, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Зураг 4. 15. Элэгний хордлогот өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он




2015 онд элэгний хордлогот өвчний 77.6 хувийг 40-өөс дээш насныхан эзэлж өвчлөлийн түвшин дунджаар 23.3 байгаа нь бусад насныхны дунджаас 10 дахин өндөр байжээ. 2019 онд энэ хандлага ижил бөгөөд 40-өөс дээш насныхны өвчлөлийн түвшин дунджаар 6.3 болж, бусад насныхны дунджаас 4.3 дахин их байна.

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Элэгний хордлогот өвчний түвшинг насны бүлгээр харвал 2019 онд 2015 онтой харьцуулахад 0-4 насанд адил, 5-19 насанд 0.1-0.3-аар нэмэгдэж, бусад насны бүлэгт 0.5-26.2-оор буурчээ.

Зураг 4. 16. Элэгний хордлогот өвчний түвшин (10000 хүнд ногдох), хүйс, насны бүлгээр, 2015, 2019 он




Элэгний хордлогот өвчний түвшин 2015 онд эмэгтэйчүүдийнх 8.8 болж, эрэгтэйчүүдээс 1.5 дахин их байсан бол 2019 онд 2.7 болж, 2015 оныхоос 3.3 дахин буурч, эрэгтэйчүүдийнхээс 0.1-ээр бага болсон байна. Насны бүлгээр харвал 2015 онд 0-9, 35-39 насанд хүйсийн ялгаа байхгүй, 10-19, 30-34 насанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 0.4-1.0-ээр их бусад насанд эмэгтэйчүүд 0.1-19.5-аар их байжээ. Харин 2019 онд энэ үзүүлэлт 0-4, 20-24, 50-59 насанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 0.1-3.2-оор бага, бусад насанд 0.1-3.1-ээр их болж өөрчлөгджээ.

## Ходоодны хорт хавдрын урьдал өвчнүүд

### Ходоод ба гэдэсний шархлаа /K25-K28/


Ходоод, гэдэсний шархлаа өвчний түвшин 2015 онд төвийн бүсэд улсын дунджаас 1.2-оор их бусад бүсэд 0.8-6.4-өөр бага байсан бол 2019 оны байдлаар улсын дунджаар 28.4 болж, 2015 оныхоос 4-өөр, бүх бүсэд 3.2-9.3-аар тус тус нэмэгджээ. Энэ үзүүлэлт 2019 онд баруун бүсэд улсын дунджаас 3.3-аар их, бусад бүсэд 1.9-6.3-аар бага байна.

Зураг 4. 17. Ходоод, гэдэсний шархлаа өвчин, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.


Зураг 4. 18. Ходоод гэдэсний шархлаа өвчин, 10000 хүн амд, аймаг, нийслэлээр, 2019 он



Ходоод, гэдэсний шархлаа өвчний түвшин 2019 онд Улаанбаатар, Архангай, Завхан, Говь-Алтай, Хэнтий, Баянхонгор, Төв, Өмнөговь аймагт улсын дунджаас 0.1-31.6-аар их, бусад аймагт 1.3-14-өөр бага байна. 2015 оноос Говь-алтай, Завхан, Увс, Ховд, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Төв, Дорнод, Хэнтий, Улаанбаатарт улсын дунджаас 0.5-20.6-аар нэмэгдэж, бусад аймагт 3-10.4-өөр буурсан байна.

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Зураг 4. 19. Ходоод, гэдэсний шархлаа өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он




Ходоод, гэдэсний шархлаа өвчний түвшинг насны бүлгээр харвал 2019 онд 2015 онтой харьцуулахад 20-29, 45-49 насанд 0.1-0.8-аар буурч бусад насанд 0.1-29.2-оор нэмэгджээ.

Ходоод, гэдэсний шархлаа өвчин бүх насны бүлэгт тохиолдож байгаа бөгөөд өвчлөлийн түвшин 2019 онд 65-аас дээш насанд хамгийн их 123.2 болж, 2015 оныхоос 29.2-оор нэмэгдсэн байна.

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Зураг 4. 20. Ходоод, гэдэсний шархлаа өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.


Ходоод, гэдэсний шархлаа өвчний түвшин 2015 онд улсын хэмжээнд эрэгтэйчүүд 26.0 болж, эмэгтэйчүүдээс 3.0-аар их, насны бүлгээр харвал 0-14, 60-аас дээш насанд эмэгтэйчүүд 0.1-9.3-аар их, бусад насанд эрэгтэйчүүд 2.0-20.7-гоор их байжээ. Харин 2019 онд эрэгтэйчүүдийн өвчлөлийн түвшин 29.6 болж, эмэгтэйчүүдээс 2.3-аар их, 0-4, 10-14 насанд 0.3-0.6-гаар бага, бусад насанд 0.1-16.2-оор их болж өөрчлөгджээ.

### Гастрит ба доуденит буюу ходоод гэдэсний үрэвсэл /K29/

Ходоодны үрэвсэлт өвчний түвшин 2019 онд 2015 онтой харьцуулахад улсын хэмжээнд 219.5 болж, 1.4 дахин, бүх бүсэд 1.1-1.6 дахин нэмэгджээ. 2015 онд баруун бүсэд улсын


дунджаас 17.6-гаар бага бусад бүсэд 16.2-27.8-аар их байсан бол 2019 онд төвийн болон зүүн бүсэд улсын дунджаас 0.3-19.4-өөр бага бусад бүсэд 4.0-8.3-аар их болжээ.

Зураг 4. 21. Ходоод гэдэсний үрэвсэлт өвчин, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.


Зураг 4. 22. Ходоод, гэдэсний үрэвсэлт өвчин, 10000 хүнд ногдохоор, аймаг, нийслэлээр, 2019 он



Ходоод гэдэсний үрэвсэлт өвчний түвшин 2019 онд Өвөрхангай, Сүхбаатар, Хөвсгөл, Завхан, Хэнтий, Говь-Алтай, Өмнөговь, Дорноговь, Ховд, Төв, Баянхонгор, аймагт улсын дунджаас 7.2-140.6-гаар их бусад аймагт 1.5-128.1-ээр бага байна.

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.


Зураг 4. 23. Ходоод, гэдэсний үрэвсэлт өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он



Ходоод гэдэсний үрэвсэлт өвчин бүх насны бүлэгт тохиолдож, 2019 оныг 2015 онтой харьцуулахад 0-14 насанд хамгийн их буюу дунджаар 2.4 дахин нэмэгдсэн байна. 15 наснаас хойш нас ахих тутам өвчлөлийн түвшин нэмэгдэж 65-аас дээш насанд 626.2 болж, 2015 оныхоос дунджаар 1.3 дахин нэмэгджээ.

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Зураг 4. 24. Ходоод, гэдэсний үрэвсэлт өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Ходоод, гэдэсний үрэвсэлт өвчний түвшинг хүйсээр харвал, 2015 онд 0-4 насанд эрэгтэй, эмэгтэй хүүхдийн өвчлөлийн түвшин адил, бусад насны бүлэгт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.2-2.0 дахин их өвчилж байжээ. Харин 2019 онд насны бүлэгт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.1-2.0 дахин их өвчилсөн байна.



## Уушгины хорт хавдрын урьдал өвчнүүд

### Уушги тэлэгдэх ба уушгины архаг бөглөрөлтэй бусад өвчнүүд /J40-J44/


Уушги тэлэгдэх ба уушгины архаг бөглөрөлт бусад өвчний түвшин улсын хэмжээнд 2019 онд 161.9 болж, 2015 оныхоос 1.8 дахин, бүх бүсэд 1.7-2.2 дахин нэмэгдсэн байна. Өвчлөлийн түвшин 2015 онд зүүн бүсэд улсын дунджаас 2-оор их бусад бүсэд 4.8-27.7-гоор бага байжээ. Харин 2019 онд хангайн болон төвийн бүсэд улсын дунджаас 2.7-21.4-өөр их нөгөө 2 бүсэд 5.0-21.8-аар бага байна.

Зураг 4. 25. Уушгины архаг бөглөрөлт өвчин, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Зураг 4. 26. Уушгины архаг бөглөрөлт өвчин, 10000 хүнд ногдохоор, аймаг, нийслэлээр, 2019 он




Уушгины архаг бөглөрөлт өвчний түвшин 2019 онд Дундговь, Баян-Өлгий, Орхон, Хэнтий, Дорноговь, Төв, Булган аймагт улсын дунджаас 23.0-132.5-аар их бусад аймаг, нийслэлд 2-92.0-оор бага байна.

Өвчлөлийн түвшин хамгийн их нь Булган аймаг, хамгийн бага нь Ховд аймаг байна.

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Зураг 4. 27. Уушгины архаг бөглөрөлт өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он




Уушгины архаг бөглөрөлт өвчний түвшин 2015 онд 15-19 наснаас эхэлж тохиолдож байсан бол 2019 онд 5-9 нас болж залуужсан байна.

Өвчлөлийн түвшин 2019 онд 2015 онтой харьцуулахад бүх насны бүлэгт 0.7-375.9-өөр нэмэгджээ. Өвчлөлийн түвшин нас ахих тусам нэмэгдэж 2019 онд 65-аас дээш насанд 920.0 болж, 2015 оныхоос 1.7 дахин нэмэгджээ.

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Зураг 4. 28. Уушгины архаг бөглөрөлт өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019 он




Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Уушгины архаг бөглөрөлт өвчний түвшинг хүйсээр харвал 2015 онд эмэгтэйчүүдийнх 100.9 болж, эрэгтэйчүүдээс 18.8-аар их байсан бол 2019 онд 182.0 болж, эрэгтэйчүүдээс 40.8-аар их, 2015 оныхоос 1.8 дахин нэмэгджээ. Насны бүлгийн хувьд 2015 онд 15-19 насанд эрэгтэйчүүд 0.9-өөр, 60-аас дээш насанд 21.9-127.0-гоор их бусад насанд эмэгтэйчүүд 5.6-41.0-ээр их өвчилж байна.

### Уушги тоосжилт /J60-65/

Улсын хэмжээнд уушги тоосжилт өвчний тохиолдол 2015 онд 191 байсан бол 2019 онд 258 болж, 65 тохиолдол буюу 35.1 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 4. 29. Уушгины тоосжилт өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он




Уушгины тоосжилт өвчний түвшин 2019 онд 0.8 болж, 2015 оныхоос 0.2-оор нэмэгдсэн байна. Өвчлөлийн түвшинг насны бүлгээр харвал 55-аас дээш насныхан бусад насныхнаас 2 дахин их өвчилж байна.

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Уушгины тоосжилт өвчний түвшинг хүйсээр, насны бүлгээр харахад 2019 онд 25-29 насанд эрэгтэй эмэгтэйчүүдийн өвчлөлийн түвшин ижил 30-аас дээш насанд эрэгтэйчүүд илүү их өвчилсөн байна. 2015 онд өвчлөлийн түвшин 10-14 насны эрэгтэйчүүд, 30-34 насны эмэгтэйчүүд өвчилж байсан бол 2019 онд эрэгтэй, эмэгтэйчүүд 25-29 насандаа өвчилж эхэлсэн байна. Өөрөөр хэлбэл 2015 онтой харьцуулахад 2019 онд эрэгтэйчүүдийн өвчилсөн нас 10 насаар хойшилж, эмэгтэйчүүдийнх 5 насаар залуужсан байна.


Зураг 4. 30. Уушгины тоосжилт өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Уушгины тоосжилт өвчний түвшин 2019 онд эрэгтэйчүүдийнх 1.3 болж, 2015 оныхоос 0.3-аар нэмэгдэж, эмэгтэйчүүдийнх адил түвшинд байна. Өвчлөлийн түвшинг насны бүлгээр харвал бүх насанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс их байна. 2019 онд өвчлөлийн түвшин 2015 онтой харьцуулахад эрэгтэйчүүдийнх 25-39, 45-49 насанд 0.1-2.0-оор нэмэгдэж, 40-44 насанд адил, 50-аас дээш насанд 0.1-1.1-ээр буурчээ. Эмэгтэйчүүдийн өвчлөлийн түвшин 2019 онд 2015 онтой харьцуулахад 25-29, 40-49, 60-64 насанд 0.1-0.8-аар нэмэгдэж бусад насанд 0.1-0.5-аар буурчээ.


Зураг 4. 31. Уушгины тоосжилт өвчний түвшин (10000 хүнд ногдох), бүсээр, 2015, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Уушгины тоосжилт өвчний түвшин 2015 онтой харьцуулахад 2019 онд баруун бүсэд 0.1-ээр буурч, бусад бүсэд 0.1-3.8-аар нэмэгдсэн байна. Өвчлөлийн түвшин 2019 онд баруун болон хангайн бүсэд улсын дунджаас 0.5-0.7-гоор бага, төвийн бүсэд адил, зүүн бүсэд 5.7-гоор их байна.

Зураг 4. 32. Уушгины тоосжилт өвчний түвшин (10000 хүнд ногдох), аймаг, нийслэлээр, 2019 он



Уушгины тоосжилт өвчний түвшин 2019 онд Орхон, Архангай, Увс, Говь-Алтай аймагт бүртгэгдээгүй, Дорнод, Сэлэнгэ, Төв, Булган, Говьсүмбэр, Хэнтий аймагт улсын дунджаас 0.1-15.9-өөр их, бусад аймаг, нийслэлд 0.1-0.7-гоор бага байна.

Өвчлөлийн түвшин 2019 онд зүүн бүсийн Хэнтий аймагт хамгийн өндөр байгааг анхаарах шаардлагатай.


Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

## Улаан хоолойн хорт хавдрын урьдал өвчнүүд

### Улаан хоолойн сөргөө /K21/


Улаан хоолойн сөргөө өвчин улсын хэмжээнд 2019 онд 16.5 болж, 2015 оныхоос 5.4-өөр, бүх бүсэд 5.1-10.9-өөр нэмэгдсэн байна. 2015 онд өвчлөлийн түвшин бүх бүсэд улсын дунджаас 2.3-6.1-ээр бага байсан бол 2019 онд баруун бүсэд улсын дунджаас 3.3-аар их бусад бүсэд 1.9-6.3-аар бага болж өөрчлөгдсөн байна.

Зураг 4. 33. Улаан хоолойн сөргөө өвчин, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.


Зураг 4. 34. Улаан хоолойн сөргөө өвчин, 10000 хүнд амд ногдохоор, аймаг, нийслэлээр, 2019 он



Улаан хоолойн сөргөө өвчний түвшин 2019 онд Улаанбаатар, Говь-Алтай, Завхан, Төв, Увс аймагт улсын дунджаас 2.9-21.2-оор их, бусад аймагт 1.1-9.8-аар бага байна. 2015 онтой харьцуулахад Говь-алтай, Завханд 5 дахин, Баянхонгорт 4 дахин, Баян-Өлгий, Булган, Дархан-уул, Дорноговь, Сүхбаатарт 3 дахин, Ховд, Өвөрхангай, Хөвсгөл, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Хэнтийд 2 дахин нэмэгдсэн байна.

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Зураг 4. 35. Улаан хоолойн сөргөө өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он




Улаан хоолойн сөргөө өвчний түвшин 2019 онд 2015 онтой харьцуулахад 0-4, 55-аас дээш насанд 0.2-22.1-ээр нэмэгдэж бусад насны бүлэгт 0.1-9.9-өөр буурчээ.

Өвчлөлийн түвшин 2019 онд бүх насны бүлэгт тохиолдож нас ахих тутам нэмэгдсээр 60-64 насанд 99.8 болж хамгийн их байна.

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Өвчлөлийн түвшинг хүйсээр харвал, 2019 онд эмэгтэйчүүдийнх 21.3 болж, эрэгтэйчүүдээс 1.8 дахин их, 2015 оныхоос 6.5-аар нэмэгдсэн байна.

Зураг 4. 36. Улаан хоолойн сөргөө өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2015, 2019 он




Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

## Умайн хүзүүний хорт хавдрын урьдал өвчнүүд

### Умайн хүзүүний шархлаа ба шамраас /N86/

Умайн хүзүүний шархлаа өвчний түвшин 2015 онд 12.2 байсан 2019 онд 4.7 болж, 2.6 дахин буурсан байна. Өвчлөлийн түвшинг насны бүлгээр харвал 2015 онд 25-64 насанд хамгийн их улсын дунджаас 1.3-2.3 дахин их байжээ. Энэ үзүүлэлт 2019 онд 25-59 насанд хамгийн их бөгөөд 2015 онтой харьцуулахад 1.9-3.7 дахин буурсан байна.


Зураг 4. 37. Умайн хүзүүний шархлаа өвчний түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2015, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Умайн хүзүүний шархлаа ба шамраас өвчний түвшинг бүс нутгаар харвал 2015 онд төвийн бүсэд улсын дунджаас 2.7-гоор их бусад бүсэд 2.6-6.1-ээр бага байсан бол 2019 онд хангай болон баруун бүсэд улсын дунджаас 0.7-4.2-оор их бусад бүсэд 1.3-1.6-гаар бага болжээ. Энэ үзүүлэлт 2019 онд 2015 онтой харьцуулахад бүх бүсэд 0.7-11.4-өөр буурчээ.

Зураг 4. 38. Умайн хүзүүний шархлаа ба шамраас, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он




Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Умайн хүзүүний шархлаа ба шамраас өвчин 2019 онд Ховд, Увс, Хөвсгөл, Төв, Булган, Өвөрхангай аймагт улсын дунджаас 0.3-19.1-ээр их бусад аймаг, нийслэлд улсын дунджаас 0.4-4.2-оор бага байна. Өвчлөлийн түвшин Ховд аймагт хамгийн өндөр, Говь-Алтай аймагт хамгийн бага байна.




Зураг 4. 39. Умайн хүзүүний шархлаа ба шамраас, 10000 хүнд ногдохоор, аймгаар, 2019 он



Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

### Умайн хүзүүний дисплази /N87/

Зураг 4. 40. Умайн хүзүүний дисплази, 10000 хүнд ногдохоор, насны бүлгээр, 2015, 2019 он



Умайн хүзүүний дисплази өвчний түвшин 2015 онд улсын дунджаар 6.1 байсан бол 2019 онд 7.0 болж, 0.9-өөр нэмэгдсэн байна. Өвчлөлийн түвшинг насны бүлгээр харахад 15-аас дээш насны эмэгтэйчүүд өвчилж, үүний дотор 30-аас дээш насны эмэгтэйчүүд хамгийн их буюу улсын дунджаас 0.6-9.6-гаар их байна. 2019 онд энэхүү үзүүлэлт 2015 онтой харьцуулахад 25-29 насанд 0.4-өөр, 35-64 насанд 0.3-4.6-гаар тус тус нэмэгдэж бусад насанд 0.1-0.5-аар буурчээ.

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Умайн хүзүүний дисплази өвчний түвшин 2015 онд төвийн бүсэд улсын дундажтай адил, бусад бүсэд улсын дунджаас 1.8-3.6-гаар бага байсан бол 2019 онд хангайн болон төвийн бүсэд улсын дунджаас 0.1-0.3-аар их бусад бүсэд 0.5-0.8-аар бага болжээ.

Зураг 4. 41. Умайн хүзүүний дисплази, 10000 хүнд ногдохоор, бүсээр, 2015, 2019 он




Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

Умайн хүзүүний дисплази өвчний түвшин 2019 онд 2015 онтой харьцуулахад бүх бүсэд 1.1-4.0-өөр нэмэгдсэн байна.

Умайн хүзүүний дисплази өвчний түвшин 2019 онд Улаанбаатар, Говь-Алтай, Хэнтий, Дархан-Уул, Орхон, Дундговь, Сэлэнгэ, Булган, Архангай, Увс аймагт улсын дунджаас 0.1-7.9-өөр их бусад аймагт 0.2-5.6-гаар бага байна.

Зураг 4. 42. Умайн хүзүүний дисплази, 10000 хүнд ногдохоор, аймаггаар, 2019 он



Өвчлөлийн түвшин хамгийн их нь Увс, хамгийн бага нь Баян-Өлгий аймаг байна.


Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн статистикийн мэдээний сан, тогтмол хаягаар түүвэрлэв.

### БҮЛЭГ 5. ХАВДРЫН НАС БАРАЛТ, ТҮҮНИЙ ШАЛТГААН


Хорт хавдрын нас баралтын түвшин, 2010-2019 оны дундаж




Хорт хавдрын нас баралтын түвшин, 2019, 2040 он



Хорт хавдрын нас баралт хүйсээр




Хорт хавдрын нас баралт, өвчний төрөл, хүйс, хувиар, 2019 он



## Хүн амын нас баралтын шалтгаан

Манай улсын хүн амын нас баралтыг зонхилох шалтгаанаар авч үзвэл, 1990 онд амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлж байсан бол 1992 оноос эхлэн одоог хүртэл зүрх судасны тогтолцооны өвчин тэргүүлэх шалтгаан болж байна.

Зураг 5.1. Хүн амын нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), зонхилон тохиолдох өвчний төрлөөр, 2010-2019 он



Хүн амын нас баралтын түвшинг зонхилох шалтгаанаар сүүлийн 10 жилийн байдлаар харвал 2019 онд зүрх судасны тогтолцооны өвчин тэргүүлж 17.3 болсон нь сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 1.5-2.7-гоор тус тус буурчээ. Нас баралтын 2 дахь шалтгаан болсон хавдрын өвчлөлийн түвшин 2019 онд 14.4 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 0.7-0.8-аар тус тус нэмэгдсэн байна. Гэмтэл хордлого ба гаднын шалтгаант бусад эмгэг, хоол боловсруулах тогтолцооны өвчний нас баралтын түвшин 3, 4 дэх шалтгаан болж 2019 онд 8.9, 3.7 болсон нь сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 0.1-0.9-өөр тус тус буурчээ. Харин нас баралтын 5 дахь шалтгаан нь амьсгалын тогтолцооны өвчин бөгөөд 2019 онд 2.5 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 0.1-0.2-оор нэмэгдсэн байна.

Нас баралтын түвшин 2019 оны байдлаар бүх өвчний төрөлд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс их бөгөөд гэмтэл, хордлого ба гаднын шалтгаант болон амьсгалын тогтолцооны өвчнөөр нас баралтын түвшин эмэгтэйчүүдээс 2-4 дахин их байна.

Нас баралтын түвшинг насны бүлгээр харвал гэмтэл хордлого ба гаднын шалтгаант өвчнөөс бусад өвчний хувьд 65-аас дээш насныхан хамгийн их бөгөөд бусад насныхны дунджаас 8.4-17.0 дахин их байна. Гэмтэл хордлого ба гаднын шалтгаант өвчний нас баралтын түвшин 20-64 насанд хамгийн их дунджаар 14.5 байна. Хоол боловсруулах тогтолцоо болон амьсгалын тогтолцооны өвчнийх зүүн бүсэд улсын дунджаас 0.1-0.2-оор их бусад бүсэд бага байна.

Нас баралтын түвшинг өвчний төрлөөр байршлаар харвал зүрх судасны тогтолцоо болон хавдрын өвчлөл хөдөөд хотоос 0.3-3.4-өөр их бусад өвчлөл хотод 0.4-4.0-өөр их байна.

Хүснэгт 5. 1. Нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), зонхилох өвчний төрөл, хүйс, насны бүлэг, байршлаар, 2019 он

Үзүүлэлт	Нийт нас баралт	Зүрх-судасны тогтолцооны өвчин	Хавдар	Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад эмгэг	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Амьсгалын тогтолцооны өвчин
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	66.8	20.8	16.2	14.4	4.2	3.4
Эмэгтэй	41.4	13.9	12.6	3.4	3.2	1.7
<b>Насны бүлэг</b>						
20 хүртэлх	12.9	0.3	0.5	2.5	0.2	1.5
20-44	21.6	3.6	2.4	10.7	1.7	0.8
45-64	111.2	35.5	36.3	18.2	9.0	3.8
65+	485.8	224.1	159.2	9.4	30.6	22.3
<b>Байршил</b>						
Хот	56.4	15.5	14.2	11.0	4.3	2.7
Хөдөө	51.9	18.9	14.5	7.0	3.1	2.3
<b>Бүсээр</b>						
Баруун	50.3	19.0	14.4	5.5	2.3	2.2
Хангайн	54.1	20.5	14.2	8.0	3.5	2.1
Төв	50.4	17.8	14.1	7.6	3.1	2.5
Зүүн	52.1	16.8	16.5	6.1	3.8	2.7
<b>Нийт</b>	<b>53.9</b>	<b>17.3</b>	<b>14.4</b>	<b>8.9</b>	<b>3.7</b>	<b>2.5</b>

Бүс нутгийн хувьд зүрх судасны тогтолцооны өвчний нас баралтын түвшин баруун, хангайн, төвийн бүсэд улсын дунджаас 0.5-3.4-өөр их байна. Хавдар өвчний нас баралт зүүн бүсэд улсын дунджаас 2.1-ээр их бусад бүсэд 0.2-0.3-аар бага байна.

Зүрх судасны тогтолцооны өвчний нас баралтын түвшин 2019 онд Сүхбаатар, Увс, Хэнтий, Өмнөговь, Орхон, Улаанбаатар, Ховд, Дорноговь, Говьсүмбэрт улсын дунджаас 0.3-9.3-аар бага бусад аймагт 0.1-6.2-оор их байна. Хамгийн их нь Хөвсгөл, хамгийн бага нь Говьсүмбэр байна.

Хавдрын нас баралтын түвшин Увс, Булган, Дорнод, Сүхбаатар, Дундговь, Дархан-Уул, Хөвсгөл, Говь-Алтай аймагт улсын дунджаас 1.8-4.3-аар их бусад аймагт 0.2-3.2-оор бага байна. Хамгийн их нь Увс 18.7, бага нь Өмнөговь аймагт 11.2 байна.

Хүснэгт 5. 2. Нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), зонхилох өвчний төрөл, аймаг, нийслэлээр, 2019 он

Аймаг, нийслэл	Нийт өвчлөл	Зүрх-судасны тогтолцооны өвчин	Хавдар	Гэмтэл хордлого ба гадны шалтгаант өвчин	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Амьсгалын тогтолцооны өвчин
Улсын дундаж	53.9	17.3	14.4	8.9	3.7	2.5
Баруун бүс	50.3	19.0	14.4	5.5	2.3	2.2
Баян-Өлгий	53.7	22.4	12.7	4.1	2.8	3.2
Говь-Алтай	52.4	20.2	16.2	6.2	2.4	1.6
Завхан	52.2	20.4	13.9	6.2	2.8	1.9
Увс	51.9	16.8	18.7	6.8	1.8	2.6
Ховд	41.8	14.9	11.5	4.6	1.6	1.5
Хангайн бүс	54.1	20.5	14.2	8.0	3.5	2.1
Архангай	57.0	23.1	13.8	9.5	3.2	2.0
Баянхонгор	54.8	19.2	11.5	8.1	5.7	2.4
Булган	51.6	20.2	18.4	5.9	2.1	2.3
Орхон	50.3	15.8	14.1	9.2	4.0	1.4
Өвөрхангай	50.7	20.1	11.8	5.6	3.9	2.9
Хөвсгөл	58.8	23.5	16.7	8.9	2.1	1.8
Төвийн бүс	50.4	17.8	14.1	7.6	3.1	2.5
Говьсүмбэр	33.3	8.0	11.5	4.6	3.4	0.6
Дархан - Уул	50.8	20.0	17.6	6.0	1.9	0.4
Дорноговь	57.3	12.1	12.9	13.9	4.3	4.7
Дундговь	54.9	20.8	17.8	7.9	1.9	2.1
Өмнөговь	49.9	16.0	11.2	8.8	3.7	2.7
Сэлэнгэ	46.5	20.0	12.0	5.0	3.4	2.1
Төв	50.9	19.0	14.0	7.4	3.2	3.9
Зүүн бүс	52.1	16.8	16.5	6.1	3.8	2.7
Дорнод	53.0	17.4	18.2	6.1	4.6	1.8
Сүхбаатар	55.9	17.0	18.0	6.4	2.9	2.2
Хэнтий	47.9	16.1	13.5	5.8	3.8	4.1
Улаанбаатар	56.4	15.5	14.2	11.0	4.3	2.7


### Хорт хавдрын шалтгаант нас баралт

Монгол улсад 2010-2019 оны хооронд 38119 хүн хорт хавдрын шалтгаанаар нас барж нийт нас баралтын 22.8 хувийг эзэлж байна. 2019 онд хорт хавдрын нас баралтын 4801 тохиолдол бүртгэгдэж, сүүлийн 10 жилийн дунджаас 989 (25.9%)-өөр, өмнөх оноос 389 (8.8)-өөр тус тус нэмэгджээ.

Хорт хавдрын нас баралтын түвшин 2019 онд 15 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 1-2-оор нэмэгджээ.


Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Халдварт бус өвчинтэй тэмцэх” үндэсний хөтөлбөрт 2019 он гэхэд хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшинг 11.6 болгох зорилт хэрэгжээгүй байна.

Зураг 5.2. Хорт хавдрын шалтгаант нас баралт, 10000 хүнд амд, 2010-2019 он




Сүүлийн 10 жилийн дунджаар хорт хавдраар өвчлөгчдийн 77.2 хувь нь хожуу үедээ оношлогдож байгааг өмнөх бүлэгт дурдсан. Тэгвэл хорт хавдраар нас барсан хүмүүсийн оношлогдсоноос хойш амьдарсан хугацааг сүүлийн 10 жилийн дунджаар харвал 73.1 хувь нь (10 хүний 7) 1 хүртэл, 22.9 хувь (10 хүний 2) нь 1-5 хүртэлх жил, 4.1 хувь (10 хүний 1) нь 5, түүнээс жил амьдарсан байна. 2019 онд 1 хүртэлх жил амьдарсан хүний эзлэх хувь 66.2 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 6.9 пунктээр буурч, 1-5 хүртэл, 5-аас дээш жил амьдарсан хүний эзлэх хувь 2.4-4.5 пунктээр нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл 2019 онд хорт хавдартай хүний оношлогдсоноос хойших амьдарсан хугацаа сүүлийн 10 жилийн дунджаас бага зэрэг нэмэгдсэн байна.

Зураг 5.3. Хорт хавдрын шалтгаант нас баралт, оношлогдсоноос хойш амьдарсан хугацаагаар, 2010-2019 он




Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин сүүлийн 10 жилийн дунджаар эрэгтэйчүүдийнх 15 болж, эмэгтэйчүүдээс 4-өөр их байна. 2019 онд эрэгтэйчүүдийнх 16 болж, эмэгтэйчүүдээс 2-оор их, сүүлийн 10 жилийн дунджаас 1-ээр нэмэгдэж өмнөх онтой адил түвшинд байна. Эмэгтэйчүүдийн хорт хавдрын нас баралтын түвшин 2019 онд 14 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 2-3-аар нэмэгджээ.

Зураг 5. 4. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, хүйсээр, 2010-2019 он




Зураг 5. 5. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, насны бүлгээр, 2010, 2019 он



Хорт хавдрын шалтгаант нас баралтыг насны бүлгээр, 2010 онтой харьцуулбал 20-29, 35-54 насанд 0.1-3.8-аар буурч, 5-9 насанд адил түвшинд, бусад насанд 0.1-28.7-гоор нэмэгдсэн байна. 2019 онд хорт хавдрын нас баралтын 48.4 хувийг 65-аас дээш насныхан эзэлж, 2010 оныхоос 0.9 пунктээр нэмэгджээ.

Зураг 5. 6. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, насны бүлэг, хүйсээр, 2010, 2019 он




Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшинг хүйсээр, насны бүлгээр харвал 2010 онд 0-4, 15-19, 25-29 насанд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 0.1-0.7-гоор их, бусад насанд 0.1-44.8-аар бага байсан байна. Харин 2019 онд 15-19, 30-39 насанд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 0.3-1.0-ээр их болж, 0-4 насанд адил, бусад насанд 0.1-67.8 болж



өөрчлөгдсөн байна. Эрэгтэйчүүдийн хорт хавдраар нас баралтын түвшин 2010 онтой харьцуулахад 2019 онд 20-24, 35-54 насныханд 0.1-5.8-аар буурч, 5-9 насанд адил, бусад насанд 0.1-44.4-өөр нэмэгдсэн байна. Энэ үзүүлэлт эмэгтэйчүүдийн хувьд 2019 онд ихэнх насны бүлэг буюу 20-29, 40-64 насанд 2010 оноос 0.5-4.7-гоор буурч, 5-9 насанд адил, бусад насанд 0.2-21.4-өөр нэмэгдсэн байна.

Зураг 5. 7. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, өвчний төрөл, хүйсээр, 2019 он



Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшинг 2019 оны байдлаар, зонхилох өвчний төрлөөр харвал эрэгтэйчүүдийн хувьд элэг, ходоод, уушги, улаан хоолой, нойр булчирхайн өвчлөл тэргүүлж байна. Эмэгтэйчүүдийн хувьд элэг, ходоод, умайн хүзүү, улаан хоолой, хөх, уушгины хавдрын шалтгаант нас баралт тэргүүлж байна.


Зураг 5. 8. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, бүсээр, 2010, 2019 он



Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин 2010 онд баруун бүсэд 11.7 болж, улсын дунджаас 0.7-гоор бага бусад бүсэд 1.8-2.9-өөр их байна. Харин 2019 онд бүс бүсэд улсын дунджаас 1.5-5.5-аар их болсон байна. 2019 онд зүүн бүсэд хамгийн их байгаа нь 2010 онтой адил, хамгийн бага нь хангайн бүс байна.


Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин 2019 онд Дорноговь, Өвөрхангай, Баян-Өлгий, Өмнөговь, Баянхонгор, Говьсүмбэр, Улаанбаатарт улсын дунджаас 0.4-2.8-аар бага, бусад аймагт 0.4-6.1-ээр их байна.

Зураг 5. 9. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, аймаг, нийслэлээр, 2019 он



Хорт хавдрын шалтгаант нас баралтын тохиолдлын бүтцийг, дүнд эзлэх хувиар харвал сүүлийн 10 жилийн байдлаар элэгний хорт хавдар тэргүүлж 2019 онд 40.1 хувийг эзэлж, сүүлийн 10 жилийн дунджаас 1.8, өмнөх оноос 1.5 пунктээр тус тус буурчээ. Хорт хавдрын нас баралтын 2 дугаар шалтгаан болсон ходоодны хорт хавдар нийт хорт хавдрын 15.3 хувийг эзэлж, сүүлийн 10 жилийн дунджаас 0.3, өмнөх оноос 0.6 пунктээр, 3 дахь шалтгаан болсон уушгины хорт хавдрынх 0.1-0.5, улаан хоолойн хавдрынх 4 дэх шалтгаан болж, 0.3-0.9-өөр тус тус буурсан байна.

Зураг 5. 10. Хорт хавдрын шалтгаант нас баралтын дүнд эзлэх хувь, зонхилох өвчний төрлөөр, 2010-2019 он



Харин 5,6 дахь шалтгаан болсон умайн хүзүү, хөхний хавдрын шалтгаант нас баралт 0.1-0.7-гоор өссөн байна. Бусад хавдрын шалтгаант нас баралт мөн сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 2.2-2.4 пунктээр өсжээ.

## Хорт хавдрын нас баралтын хандлага

Хорт хавдраар нас барагчдын сүүлийн 10 жилийн байдлаарх өсөлт, бууралтын хандлагыг Үндэсний статистикийн хорооноос тооцсон хүн амын 2045 он хүртэлх хэтийн тооцоог ашиглан хорт хавдраар, нас барагчдын түвшинг зонхилон тохиолдох өвчний төрлөөр 2045 он хүртэлх таамаглалыг эксел программын trendline оруулж өнгөрсөн 10 жилийн хугацааны өсөлт, бууралттай хамгийн ойролцоо тэгшитгэлийн загварыг ашиглан тооцсон.

Хорт хавдрын нийт нас баралтын хувьд polynomial загварын  $y = 12.348x^2 + 35.718x + 3140.7$ ;  $R^2 = 0.9124$ ;

Элэгний хорт хавдар: polynomial  $y = 5.3333x^2 + 0.0848x + 1386.4$ ;  $R^2 = 0.8173$ ;


Ходоодны хорт хавдар: polynomial  $y = 0.4318x^2 + 24.353x + 446.03$ ;  $R^2 = 0.8784$ ;

Уушгины хорт хавдар: polynomial  $y = 2.0492x^2 - 7.4932x + 321.82$ ;  $R^2 = 0.8994$ ;

Умайн хүзүүний хорт хавдар: polynomial  $y = 0.2917x^2 + 1.5735x + 123.42$ ;  $R^2 = 0.3894$ ;

Улаан хоолойн хорт хавдар: polynomial  $y = 1.2348x^2 - 9.753x + 292.7$ ;  $R^2 = 0.4925$ ;  
томьёог ашигласан.

Зураг 5. 11. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, зонхилох өвчний төрлөөр, 2010-2045 он



Хорт хавдрын нас баралтын түвшин 2010-2014 оны дунджаар 12.2 байсан бол 2015-2019 оны дунджаар 13.8 болж, 1.3-гаар өссөн байна.


Хорт хавдрын нас баралтыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийг үр дүнтэй болгон, сайжруулахгүй, хүн амын өсөлтийн түвшин энэ хэвээр байна гэж үзвэл 2045 он гэхэд нийт хорт хавдрын нас баралтын түвшин 3 дахин өсөхөөр байна.

Элэгний хорт хавдрын нас баралтын түвшин 2010-2014 оны дунджаар 5.2 байсан бол сүүлийн 5 жилийн дунджаар 5.7 болж, 0.5-аар, 2045 он гэхэд 16.6 болж одоогийнхоос мөн л 3 дахин өсөхөөр байна.

Монгол Улсын Засгийн газраас 2017 оноос хойш “Элэг бүтэн монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж өвчлөлийн түвшин буурсан боловч элэгний хавдрын нас баралтын түвшин буурахгүй байна. Иймээс энэхүү хөтөлбөрийг сайжруулан, хэрэгжилтийг үр дүнтэй болгоход анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хорт хавдрын 2 дахь шалтгаан болсон ходоодны хорт хавдрын нас баралтын түвшин 2010-2014 оны дунджаар 1.9 байсан бол сүүлийн 5 жилийн дунджаар 2.2 болж, 0.3-аар нэмэгдэж, 2045 он гэхэд 3.8 болж өсөх хандлагатай байна.

Зураг 5. 12. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, зонхилох өвчний төрлөөр, 2010-2045 он




Уушгины хорт хавдрын шалтгаант нас баралт 2010-2014 оны дунджаар 1.2 байсан бол сүүлийн 5 жилийн дунджаар 1.3 болж нэмэгдсэн байна. Энэ үзүүлэлт 2045 он гэхэд 3.1 болж өсөхөөр байна.

Умайн хүзүүний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин 2010-2014 оны дунджаар 0.5 байсан бол сүүлийн 5 жилийн дунджаар өөрчлөгдөөгүй байна. Монгол Улсын хэмжээнд умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж өвчлөл буурсан ч нас баралтын түвшин буурахгүй байна. Энэ хэвээр нас баралтын түвшинг бууруулах бодлого хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхгүй бол 2045 он гэхэд нас баралтын түвшин 1.1 болж өсөхөөр байна.

### Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт


Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын тохиолдол сүүлийн 10 жилд 15.9 мянга бүртгэгдэж, нийт хорт хавдрын нас баралтын 41.8 хувийг эзэлж байна. 2019 онд элэгний хорт хавдрын 1926 нас баралт бүртгэгдэж, сүүлийн 10 жилийн дунджаас 334 (21.0%)-өөр, өмнөх оноос 89 (4.8%)-өөр тус тус нэмэгджээ

Зураг 5. 13. Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт, (10000 хүнд ногдох) 2010-2019 он




Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин 2019 онд 6.0 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 0.2-0.6-гаар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 5. 14. Элэгний хорт хавдрын нас баралт, анх оношлогдсоноос хойших амьдарсан хугацаа, хувиар, 2010-2019 он




Элэгний хорт хавдрын оношлогдсоноос хойших амьдарсан хугацааг харвал сүүлийн 10 жилийн дунджаар 72.9 хувь нь 1 хүртэл жил, 23.6 хувь нь 1-5 хүртэлх, 3.5 хувь нь 5, түүнээс дээш жил байна. 2019 онд 1 хүртэлх жил амьдарсан хувь 63.9 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 9.3 пунктээр буурч, 1-5, 5-аас дээш жил амьдарсан хувь 2-7.3 пунктээр нэмэгдсэн байна. Харин өмнөх онтой харьцуулахад 1 хүртэлх жил амьдарсан хувь 1.5 пунктээр нэмэгдэж, 1-5, 5-аас дээш жил амьдарсан хувь энэ хэмжээгээр буурсан байна.

Зураг 5. 15. Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), хүйсээр, 2010-2019 он.



Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт эрэгтэй, эмэгтэйчүүдийн нас баралтын тэргүүлэх шалтгаан бөгөөд сүүлийн 10 жилийн дунджаар эрэгтэйчүүдийнх 6.4 болж, эмэгтэйчүүдээс 1.7-гоор их байна. 2019 онд эрэгтэйчүүдийн нас баралтын түвшин 6.6 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 0.2-оор, эмэгтэйчүүдийнх 5.5 болж, 0.2-0.7-гоор тус тус нэмэгджээ.


Зураг 5. 16. Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2010-2019 он



Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшинг насны бүлгээр харвал 65-аас дээш насныхан илүү их өвчилж, нас барж байна. 2010 онд 65-аас дээш насныхан нийт элэгний хавдраар нас барагчдын түвшин 71.6 байсан бол 2019 онд 62.7 болж, 9-өөр буурсан байна. 2019 онд 2010 онтой харьцуулахад 25-29 насанд нас баралтын түвшин адил бусад насны бүлэгт 0.1-4.2-оор нэмэгдсэн байна. 2019 онд элэгний хавдрын шалтгаант нас баралтын түвшин 2010 оноос насны хувьд залуужсан байна.


Өөрөөр хэлбэл 2010 онд 25-29 насанд нас баралтын тохиолдол илэрсэн бол 2019 онд 15-19 насанд илэрчээ.

Зураг 5. 17. Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2010, 2019 он




Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшинг бүс, нутгаар харвал 2010 онд баруун бүсэд 4.6 болж, улсын дунджаас 0.7-гоор бага бусад бүсэд 0.5-1.7-гоор их байжээ. Харин 2019 онд энэ үзүүлэлт бүх бүсэд улсын дунджаас 0.5-4.4-өөр их болсон байна.

Зураг 5. 18. Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), бүсээр, 2010, 2019 он



Элэгний хорт хавдраар нас баралтын түвшинг (10000 хүнд ногдох) 2019 оны байдлаар аймаг, нийслэлээр харвал Өвөрхангай, Баянхонгор, Улаанбаатар, Говьсүмбэр, Өмнөговь, Баян-Өлгийд улсын дунджаас 0.1-2.1-ээр бага бусад аймагт 0.2-5.3-аар их байна. Хамгийн их нь Хэнтий аймагт 11.3, хамгийн бага нь Баян-Өлгий аймаг байна.

Зураг 5. 19. Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, аймаг, нийслэлээр, 2019 он



## Ходоодны хорт хавдрын шалтгаант нас баралт


Ходоодны хорт хавдрын шалтгаант нас баралт нийт хорт хавдраар нас баралтын 2 дахь шалтгаан болж, сүүлийн 10 жилийн байдлаар нийт 5966 тохиолдол бүртгэгдсэн байна. 2019 онд ходоодны хорт хавдрын нас баралтын 736 тохиолдол бүртгэгдэж, сүүлийн 10 жилийн дунджаас 139 (23.4%)-өөр, өмнөх оноос 31 (4.4%)-ээр тус тус нэмэгдсэн байна.

Зураг 5. 20. Ходоодны хорт хавдрын шалтгаант нас баралт, 2010-2019 он



Ходоодны хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин 2019 онд 2.3 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 0.1-0.3-аар тус тус нэмэгдсэн байна.


Зураг 5. 21. Ходоодны хорт хавдрын нас баралт, анх оношлогдсоноос хойших амьдарсан хугацаа, хувиар, 2010-2019 он



Ходоодны хорт хавдраар анх оношлогдсоноос хойших амьдарсан хугацааг сүүлийн 10 жилийн дунджаар харвал 76.2 хувь нь 1 хүртэлх, 21.1 хувь нь 1-5 хүртэлх, 2.7 хувь нь 5-аас дээш жил байна. 2019 онд 1 хүртэлх жил амьдарсан хувь 62.5 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 4.5 пунктээр буурч, өмнөх оноос 0.2 пунктээр нэмэгдсэн байна. Харин 1-5 хүртэлх жил амьдарсан хувь 2019 онд 35.8 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 0.5-0.6 пунктээр тус тус нэмэгдсэн байна. Таваас дээш жил амьдарсан хувь 2019 онд 1.8 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 1.9 пунктээр нэмэгдэж, өмнөх оноос 0.8 пунктээр буурчээ.




Зураг 5. 22. Ходоодны хорт хавдрын нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), насны бүлгээр, 2010, 2019 он



Ходоодны хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшинг насны бүлгээр харвал 65-аас дээш насныхан хамгийн их бөгөөд 2019 онд 2010 оныхтой харьцуулахад 50-64, 65-аас дээш насанд 0.2-2.3-аар нэмэгдэж, 25-34 насанд адил, 35-49 насанд 0.5-0.7-гоор буурсан байна.


2010 онд 20-24 насанд нас баралтын тохиолдол бүртгэгдсэн бол 2019 онд 15-19 нас болж залуужсан байна.

Зураг 5. 23. Ходоодны хорт хавдрын нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), насны бүлэг, хүйсээр, 2010, 2019 он




Ходоодны хорт хавдрын нас баралтын түвшин эрэгтэйчүүдийнх 2019 онд 3.2 болж, эмэгтэйчүүдээс 1.7-гоор, 2010 оныхоос 0.7-гоор тус тус их байна. Эмэгтэйчүүдийн нас баралтын түвшин 2019 онд 1.5 болж, 2010 оныхоос 0.1-ээр нэмэгджээ. 2010 онд 25-29 насны эмэгтэйчүүдийн нас баралтын түвшин эрэгтэйчүүдээс 0.1-ээр их бусад насанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 0.1-12.5-аар их байсан бол 2019 онд 15-24, 30-34 насанд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 0.1-0.3-аар их, бусад насанд эрэгтэйчүүд 0.1-23.2-оор их байна.

Зураг 5.24. Ходоодны хорт хавдрын нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), бүсээр, 2010, 2019 он



Ходоодны хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшинг бүс нутгаар харвал 2010 онд хангайн бүс улсын дунджаас 0.1-ээр бага бусад бүсэд 0.2-0.4-өөр их байжээ. Харин 2019 онд зүүн бүсэд улсын дунджаас 0.1-ээр бага бусад бүсэд 0.3-0.8-аар их байна. Ходоодны хорт хавдрын нас баралтын түвшин 2010 онд зүүн бүсэд хамгийн өндөр байсан бол 2019 онд баруун бүсэд хамгийн их байна.

Зураг 5. 25. Ходоодны хорт хавдрын нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), аймаг, нийслэлээр, 2019 он




Энэ үзүүлэлт 2019 онд Баян-Өлгий, Дундговь, Сүхбаатар, Улаанбаатар, Өмнөговь, Хэнтий, Баянхонгор аймагт улсын дунджаас 0.1-1.6-гаар бага, Архангай аймагт улсын дундажтай адил, бусад аймагт 0.1-1.8-аар их байна.

### Уушгины хорт хавдрын шалтгаант нас баралт

Сүүлийн 10 жилд уушгины хорт хавдрын нас баралтын 3595 тохиолдол бүртгэгдэж, нийт хорт хавдрын 9.4 хувийг эзэлж, хавдрын нас баралтын 3 дахь тэргүүлэх шалтгаан болж байна.


Зураг 5. 26. Уушгины хорт хавдрын нас баралт, 10000 хүнд ногдох түвшин, 2010-2019 он



2019 онд уушгины хорт хавдрын шалтгаант нас баралт 451 бүртгэгдэж, сүүлийн 10 жилийн дунджаас 92 (25.5%)-оор, өмнөх оноос 15 (3.4%)-аар тус тус нэмэгджээ.


Харин уушгины хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин 2019 онд 1.4 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 0.2-оор нэмэгдэж, өмнөх онтой адил түвшинд байна.

Зураг 5. 27. Уушгины хорт хавдрын нас баралт, анх оношлогдсоноос хойш амьдарсан хугацаа, хувиар, 2010-2019 он



Уушгины хорт хавдраар анх оношлогдсоноос хойш амьдарсан хугацааг дүнд эзлэх хувиар, сүүлийн 10 жилийн дунджаар харвал 84.0 хувь нь 1 хүртэл, 14.7 хувь нь 1-5 хүртэлх, 1.4 хувь нь 5-аас дээш жил амьдарсан байна. 2019 онд 1 хүртэлх жил амьдарсан хувь 83.4 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 0.6 пунктээр буурч, өмнөх оноос 3.1 пунктээр нэмэгджээ. Харин 1-5 хүртэлх жил амьдарсан хувь 2019 онд 15.7 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 1.1-ээр нэмэгдэж, өмнөх оноос 2.6-гаар буурчээ. Таваас дээш жил амьдарсан хувь 2019 онд 0.9 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 0.5 пунктээр тус тус буурсан байна.


Зураг 5. 28. Уушгины хорт хавдрын нас баралтын түвшин, насны бүлгээр, 2010, 2019 он



Уушгины хорт хавдрын нас баралтын түвшинг насны бүлгээр харвал 2010 онд 65-аас дээш насанд хамгийн их бөгөөд 12.4 байсан бол 2019 онд 18.1 болж, 5.7-гоор нэмэгдсэн байна. 2019 онд 25-34, 55-64 насанд нас баралтын түвшин 2010 онтой харьцуулахад 0.1-1.1-ээр нэмэгдэж, 40-49 насанд адил, бусад насанд 0.1-0.2-оор буурч, 35-39, 50-54 насанд адил түвшинд байна. Уушгины хавдрын нас баралт 2010 онд 25-29 насанд тохиолдож байсан бол 2019 онд 20-24 нас болж залуужсан байна.


Уушгины хорт хавдрын нас баралтын түвшин 2019 онд эрэгтэйчүүдийнх 2.3 болж, эмэгтэйчүүдээс 1.7-гоор, 2010 оныхоос 0.3-аар нэмэгджээ. Эрэгтэйчүүдийн нас баралтын түвшин 2010 онд 20-24 насанд эмэгтэйчүүдээс 0.1-ээр бага, бусад насанд 0.1-22.6-гаар их байсан бол 2019 онд 25-29, 35-44 насанд эмэгтэйчүүдээс 0.1-ээр бага бусад насанд 0.1-28.2-оор их болж өөрчлөгдсөн байна.

Зураг 5. 29. Уушгины хорт хавдрын нас баралтын түвшин, хүйс, насны бүлгээр, 2010, 2019 он




Уушгины хорт хавдрын нас баралтын түвшинг бүсээр харвал 2010 онд баруун бүс хамгийн бага буюу улсын дунджаас 0.4-өөр бага, хангайн бүсэд улсын дундажтай адил, зүүн болон төвийн бүсэд 0.3-0.5-аар их байжээ. Харин 2019 онд бүх бүсэд улсын дунджаас 0.1-0.7-гоор их байна. Нас баралтын түвшин 2010 онд төвийн бүсэд хамгийн их байсан бол 2019 онд зүүн бүсэд их байна.

Зураг 5. 30. Уушгины хорт хавдрын нас баралтын түвшин, хүйс, насны бүлгээр, 2010, 2019 он



Уушгины хорт хавдрын нас баралтын түвшин 2019 онд Дорнод, Сэлэнгэ, Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Архангай, Улаанбаатар, Баян-Өлгий, Говьсүмбэрт улсын дунджаас 0.1-1.4-өөр бага, Өмнөговь аймагт улсын дундажтай адил, бусад аймагт 0.1-1.9-өөр их байна. Энэ үзүүлэлт хамгийн өндөр нь зүүн бүсийн Сүхбаатар, хамгийн бага нь төвийн бүсийн Говьсүмбэрт байна.

Зураг 5. 31. Уушгины хорт хавдрын нас баралтын түвшин, аймаг, нийслэлээр, 2019 он



### Улаан хоолойн хорт хавдрын шалтгаант нас баралт


Сүүлийн 10 жилд улаан хоолойн хорт хавдрын нас баралтын 2866 тохиолдол бүргэгдэж, нийт хорт хавдрын 7.5 хувийг эзэлж байна. 2019 онд улаан хоолойн хорт хавдрын нас баралт 320 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 33 (11.7%)-аар, өмнөх оноос 13 (4.2%)-аар тус тус нэмэгджээ.

Зураг 5. 32. Улаан хоолойн хорт хавдрын нас баралт, 10000 хүнд ногдох түвшин, 2010-2019 он




Улаан хоолойн хорт хавдраар нас баралтын түвшин 2019 онд 1 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх онтой адил түвшинд байна.

Зураг 5. 33. Улаан хоолойн хорт хавдрын нас баралт, анх оношлогдсоноос хойш амьдарсан хугацаа, хувиар, 2010-2019 он



Улаан хоолойн хорт хавдрын анх оношлогдсоноос хойш амьдарсан хугацааг хувиар харахад бусад хавдрын адил сүүлийн 10 жилийн дунджаар 1 хүртэлх жил амьдарсан хувь хамгийн их 77.7, 1-5 хүртэлх нь 19.8, 5-аас дээш жил амьдарсан хувь 2.5 байна. Энэ үзүүлэлтийг 2019 оны байдлаар сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх онтой харьцуулахад 1 хүртэлх жил амьдарсан хувь 77.5 болж, 0.2-1.0 пунктээр буурчээ. Харин 1-5 хүртэлх жил амьдарсан хувь 1.5-5.0 пунктээр нэмэгдсэн байна. 5-аас дээш жил амьдарсан хувь 1.3-4.0 пунктээр тус тус буурчээ.


Зураг 5. 34. Улаан хоолойн хорт хавдрын нас баралтын түвшин, насны бүлгээр, 2010, 2019 он



Улаан хоолойн нас баралтын тохиолдлыг насны бүлгээр харахад 2010 онд эрэгтэйчүүдийнх 35-39 насанд тохиолдсон бол эмэгтэйчүүдийнх 45-49 насанд байна. Энэ үзүүлэлт 2019 онд эрэгтэйчүүдийнх 2010 онтой адил, эмэгтэйчүүдийн 40-44 болж урагшилсан байна.


Улаан хоолойн нас баралтын түвшин 65-аас дээш насанд хамгийн их бөгөөд 2010 онтой харьцуулахад 2019 онд 60-64, 65-аас дээш насныхны нас баралтын түвшин 2.0-4.1-ээр буурч, бусад насных 0.1-0.7-гоор нэмэгдсэн байна.

Зураг 5. 35. Улаан хоолойн хорт хавдрын нас баралтын түвшин, хүйс, насны бүлгээр, 2010, 2019 он



Улаан хоолойн хорт хавдрын нас баралтын түвшин 2019 онд эрэгтэйчүүдийнх 1.1 болж, эмэгтэйчүүдээс 0.2-оор их, 2010 оныхоос 0.2-оор буурсан байна. Нас баралтын түвшин 2010 онд 55-59 насанд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.5-аар их, бусад насанд эрэгтэйчүүд 0.1-7.5-аар их байна. Харин 2019 онд энэ үзүүлэлт бүх насны бүлэгт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 0.1-4.1-ээр их байна.


Зураг 5. 36. Улаан хоолойн хорт хавдрын нас баралтын түвшин, бүсээр, 2010, 2019 он



Улаан хоолойн хорт хавдрын нас баралтын түвшин 2010 онд зүүн бүсэд улсын дунджаас 0.4-өөр бага бусад бүсэд 0.2-0.7-гоор их байжээ. 2019 онд төвийн болон зүүн бүсэд

улсын дунджаас 0.1-ээр бага хангайн болон баруун бүсэд 0.2-1.1-ээр их болжээ. 2010 онд нас баралтын түвшин баруун бүсэд хамгийн их байсан бол 10 жилийн дараа мөн л их байна.

Зураг 5. 37. Улаан хоолойн хорт хавдрын нас баралтын түвшин, аймаг, нийслэлээр, 2019 он




Улаан хоолойн хорт хавдрын нас баралтын түвшин 2019 онд Төв, Улаанбаатар, Сүхбаатар, Өмнөговь, Сэлэнгэ, Дорноговь, Дундговь, Хэнтий, Булганд улсын дунджаас 0.1-0.7-гоор бага, Баянхонгор, Говь-Алтай аймагт улсын дундажтай адил, бусад аймагт 0.1-2.1-ээр их байна. Нас баралтын түвшин хамгийн их нь баруун бүсийн Баян-Өлгий, хамгийн бага нь Булган аймаг байна.

### Умайн хүзүүний хорт хавдрын шалтгаант нас баралт

Сүүлийн 10 жилд умайн хүзүүний хорт хавдрын нас баралтын 1433 тохиолдол бүргэгдэж, нийт хорт хавдрын 3.8 хувийг эзэлж байна. 2019 онд умайн хүзүүний хорт хавдрын нас баралт 191 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 48 (33.3%)-аар, өмнөх оноос 45 (30.8%)-аар тус тус нэмэгджээ.


Зураг 5. 38. Умайн хүзүүний хорт хавдрын нас баралт, 2010-2019 он



Умайн хүзүүний хорт хавдрын нас баралтын түвшин 2019 онд 0.6 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 0.1-ээр тус тус нэмэгджээ.




Зураг 5. 39. Умайн хүзүүний хорт хавдрын нас баралт, анх оношлогдсоноос хойш амьдарсан хугацаа, хувиар, 2010-2019 он



Умайн хүзүүний хорт хавдраар өвчлөгчдийн анх оношлогдсоноос хойш амьдарсан хугацааг хувиар харахад бусад хавдрын адил сүүлийн 10 жилийн дунджаар 1 хүртэлх жил амьдарсан хувь хамгийн их 49.4, 1-5 хүртэлх нь 34.8, 5-аас дээш жил амьдарсан хувь 15.7 байна. Энэ үзүүлэлтийг 2019 оны байдлаар сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх онтой харьцуулахад 1 хүртэлх жил амьдарсан хувь 33.0 болж, 2.6-16.4 пунктээр буурчээ. Харин 1-5 хүртэлх жил амьдарсан хувь 4.9-9.1 пунктээр нэмэгдсэн байна. 5-аас дээш жил амьдарсан хувь сүүлийн 10 жилийн дунджаас 7.3-аар нэмэгдэж, өмнөх оноос 2.3 пунктээр буурчээ. Зураг

Зураг 5. 40. Умайн хүзүүний хорт хавдрын нас баралтын түвшин, насны бүлгээр, 2010, 2019 он




Умайн хүзүүний нас баралтын түвшин 2010 онд 25-29 насанд тохиолдож байсан бол 2019 онд 30-34 болж 5 насаар хойшилсон байна. 2019 онд умайн хүзүүний хорт хавдраар нас барагчдын 87.0 хувь нь 45-аас дээш насныхан бөгөөд 2010 онтой харьцуулахад 11.5 пунктээр нэмэгдсэн байна. Нас барагчдын түвшин 2019 онд 2010 онтой харьцуулахад 25-54 насанд 0.2-0.8-аар буурч, 55-аас дээш насанд 0.6-2.9-өөр нэмэгдсэн байна.

Зураг 5. 41. Умайн хүзүүний хорт хавдрын нас баралтын түвшин, бүсээр, 2010, 2019 он



Умайн хүзүүний хорт хавдрын түвшин 2010 онд баруун бүсэд улсын дунджаас 0.1-ээр бага, хангайн бүсэд улсын дундажтай адил, төвийн болон зүүн бүсэд улсын дунджаас 0.3-аар их байжээ. 2019 онд энэ үзүүлэлт баруун бүсэд дунджаас 0.3-аар бага, зүүн бүсэд адил, хангайн болон төвийн бүсэд улсын дунджаас 0.1-0.4-өөр их болжээ. 2010 онтой харьцуулахад зүүн болон баруун бүсэд 0.1-0.2-оор буурч төвийн, хангайн бүсэд 0.2-0.3-аар нэмэгджээ.

Зураг 5. 42. Умайн хүзүүний хорт хавдрын нас баралтын түвшин, аймаг, нийслэлээр, 2019 он



Умайн хүзүүний хорт хавдрын нас баралтын түвшин 2019 оны байдлаар аймаг, нийслэлээр харвал Говьсүмбэр, Ховд, Сүхбаатар аймагт бүртгэгдээгүй бөгөөд Дорноговь, Улаанбаатар, Архангайд улсын дунджаас 0.1-0.2-оор бага, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь аймагт улсын дундажтай адил, бусад аймагт улсын дунджаас 0.1-0.8-аар их байна. Нас баралтын түвшин хамгийн өндөр нь Өмнөговь аймаг байна.

## БҮЛЭГ 6. ДҮГНЭЛТ

### Хавдрын өвчлөл

- Хавдар өвчин нийт өвчлөлийн 14 дүгээрт, нас баралтын 2 дугаарт орж хүйсийн хувьд 30-44 насанд эмэгтэйд, 45-аас дээш насанд эрэгтэйд илүү тохиолдож байна.
- Хорт хавдрын өвчлөлийн түвшинг бүс нутгаар харахад 10 жилийн өмнө төвийн бүсэд өндөр байсан бол 2019 оны байдлаар зүүн бүсэд өндөр байна. Өвчлөл тус бүрээр харвал элэгний хорт хавдар зүүн бүсэд, ходоодны хорт хавдар баруун бүсэд, уушгины хорт хавдар зүүн бүсэд, умайн хүзүүний хорт хавдар төвийн бүсэд өндөр байна.
- Хавдар өвчин эрхтэн тогтолцоогоор нь харвал хоол боловсруулах эрхтэн (элэг, ходоод, улаан хоолой), амьсгалын (уушиг), шээс бэлгийн (хөх, умайн хүзүү) тогтолцооны хавдрууд зонхилж байна.
- Монгол Улсад нийт хорт хавдрын шинэ өвчлөлийн түвшин 2001-2014 оны дунджаар 15.7 байсан бол сүүлийн 2015-2019 оны дунджаар 18.8 болж, 3.1-ээр өссөн бол 2041-2045 оны дунджаар 29.2 болж, 10.5-аар өсөх хандлагатай байна. Үүний дотор элэг, ходоод, уушги, улаан хоолойн өвчлөл өсч, харин умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл буурах хандлагатай байна. Умайн хүзүүний хорт хавдар буурч байгаа нь эрт илрүүлэг үзлэг хийж байгаатай холбоотой бөгөөд үүнийг цаашид үргэлжлүүлэн зохион байгуулах, бусад өвчлөлийн хувьд тусгайлсан бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### Хавдрын урьдал өвчин, тэдгээрийн тархалтын төлөв байдал

Хавдрын урьдал өвчнийг амбулаторийн үзлэгт хамрагдсан, давхардсан тохиолдлоор судалсан бөгөөд бүс нутгаар харвал хорт хавдрын өвчлөлтэй адил байна. Хүйсийн хувьд хавдрын урьдал өвчнүүд эмэгтэйчүүдэд их тохиолдож байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж харин эрэгтэйчүүд өвчнийг хавдар болсон хойно нь эмнэлэгт хожуу хандаж байгаатай холбоотой. Иймээс эрэгтэйчүүдийн хавдар өвчнийг эрт илрүүлэх бодлого, хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

### Хавдрын нас баралт, түүний шалтгаан

- Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Халдварт бус өвчинтэй тэмцэх” үндэсний хөтөлбөрт 2019 он гэхэд хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшинг 11.6 болгох зорилт хэрэгжээгүй байна.
- Хорт хавдрын нас баралтыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийг үр дүнтэй болгон, сайжруулахгүй, хүн амын өсөлтийн түвшин энэ хэвээр байна гэж үзвэл 2045 он гэхэд нийт хорт хавдрын нас баралтын түвшин 3 дахин өсөхөөр байна. Монгол Улсын Засгийн газраас 2017 оноос хойш “Элэг бүтэн монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж өвчлөлийн түвшин буурсан боловч элэгний хавдрын нас баралтын түвшин буурахгүй байна. Иймээс энэхүү

хөтөлбөрийг сайжруулан, хэрэгжилтийг үр дүнтэй болгоход анхаарч ажиллах шаардлагатай байна.

- Ходоод, уушги, улаан хоолойн хорт хавдрын нас баралтын түвшин цаашид өсөх хандлагатай байна. Иймээс эдгээр өвчний хавдрын нас баралтын түвшинг бууруулах чиглэлээр тусгайлсан бодлого хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлэх зүйлшгүй шаардлагатай байна.
- Умайн хүзүүний хорт хавдрын шалтгаант нас баралтыг бууруулах зорилгоор эрт илрүүлгийн үзлэг оношилгооны хөтөлбөрийг сайжруулан, үргэлжлүүлэхэд анхаарах хэрэгтэй.

### **Хавдрын илрүүлэг, хяналт, тандалтын мэдээнд хийсэн дүн шинжилгээ**

- Улсын хэмжээнд 2019 оны байдлаар умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн 38.6 хувь нь хамрагдсан байна. Энэ үзүүлэлт жил бүр Улаанбаатарт улсын болон аймгийн дунджаас байнга бага байгаа нь анхаарал татаж байна.
- Нас ахих тусам хорт хавдраар өвчлөх эрсдэл нэмэгдэж байхад умайн хүзүүний хорт хавдрын илрүүлэг үзлэгт 50-аас дээш насны эмэгтэйчүүдийн хамрагдалт бусад насны ангилалтай харьцуулахад бага байна.
- Хорт хавдрын шинэ өвчлөлийн оношлогдсон үе шатыг сүүлийн 10 жилийн дунджаар харвал 10 хүний нь эрт үедээ, 8 нь хожуу үедээ оношлуулж байна.
- Монгол Улсад хорт хавдрын хяналтад хамрагдалтын хувь 2019 онд эрэгтэйчүүдийнх 35.5 хувь болж, 2010 оныхоос 2.1 пунктээр буурчээ. Хяналтад хамрагдалтын хувь 2019 онд бүх бүсэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 15.2-33.7 пунктээр их байна. Хорт хавдрын өвчлөлийн түвшин эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдээс илүү байсан боловч хяналтад хамрагдалт эрэгтэйчүүдийн хувьд бага байна.
- Зонхилон тохиолдох хорт хавдрын хяналтад байгаа хүмүүсийн 5, түүнээс дээш жил амьдарсан хувь 2019 онд умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл хамгийн их 51.8, хамгийн бага нь элэгний хорт хавдрынх 21.0 байна.
- Монгол Улсын Засгийн газраас “Халдварт бус өвчинтэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийн 2017-2021 оны хооронд хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд тус хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд элэгний хорт хавдрын эр үеийн илрүүлгийн хувийг 2019 онд 20.7 болгох зорилт тавьсан нь 2019 онд биелсэн байна. Харин умайн хүзүүний хорт хавдрыг I дүгээр шатанд илрүүлэх хувийг 2019 онд 42.5 болгох зорилт 2019 онд 15.2 болж биелээгүй байна.

<sup>1</sup> Bray F, Jemal A, Grey N, Ferlay J, Forman D. Global cancer transitions according to the Human Development Index (2008-2030): a population-based study. *Lancet Oncol* 2012;13:790-801 [PubMed] [Google Scholar]

<sup>2</sup> Plummer M, de Martel C, Vignat J, et al Global burden of cancers attributable to infections in 2012: a synthetic analysis. *Lancet Glob Health* 2016;4:e609–e616. doi:10.1016/S2214-109X(16)30143-7

<sup>3</sup> WHA Resolution 70.12. [http://apps.who.int/gb/ebwha/pdf\\_files/WHA70/A70\\_R12-en.pdf](http://apps.who.int/gb/ebwha/pdf_files/WHA70/A70_R12-en.pdf)

<sup>4</sup> WHO. Assessing national capacity for the prevention and control of NCDs. 2016

---

<sup>5</sup> Farmer P, Frenk J, Knaul FM, et al Expansion of cancer care and control in countries of low and middle income: a call to action. *Lancet* 2010;376:1186–93. doi:10.1016/S0140-6736(10)61152-XCrossRefPubMedWeb of ScienceGoogle Scholar

<sup>6</sup> Jazag A, Puntsagdulam N, Chinburen J. Status quo of chronic liver diseases, including hepatocellular carcinoma, in Mongolia. *Korean J Intern Med* 2012;27:121–7.

<sup>7</sup> Dorzhgotov B. Risk factors in the manifestations of the 5 principal forms of cancer in the People's Republic of Mongolia. *Sante Publique (Bucur)* 1989;32:361–7.

<sup>8</sup> Sloan FA, Gelband H, eds. Cancer causes and risk factors and the elements of cancer control. In: *Cancer control opportunities in low- and middle-income countries*. Washington, DC: The National Academies Press, 2007. 27–69.